

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ-2014

Эцсийн тайлан

IRIM судалгааны хүрээлэн

20 12 2014

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал: мониторингийн тайлан” 2014 судалгааг Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн санаачилгаар IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэв.

Мониторингийн багийн ахлагч

Хүрэлчулууны Баярмаа. IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Социологич

Зөвлөх:

Чүлтэмсүрэнгийн Тамир. Монгол Улсын Их Сургуулийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн багш, Социологийн докторант

Ахлах судлаач:

Сарантуяагийн Мойлтмаа. IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач, Хуульч

АГУУЛГА

АГУУЛГА	3
БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС.....	5
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	7
ДҮРСИЙН ЖАГСААЛТ	8
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	10
ОРШИЛ.....	11
1 МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ	13
1.1 Мониторингийн зорилго, зорилт	13
1.2 Мониторингийн хамрах хүрээ	13
1.3 Мониторингийн үзүүлэлтүүд	14
2 ГОЛ ҮР ДҮН	17
2.1 Мэдээллийн хамааралтай байдал	17
2.2 Мэдээллийн найдвартай байдал	18
2.3 Мэдээллийн цаг үеийн байдал.....	19
2.4 Мэдээллийн хүртээмжтэй байдал.....	19
2.5 Цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал	20
3 ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ.....	22
3.1 Үйл ажиллагааны ил тод байдал.....	24
3.1.1 Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл.....	24
3.2 Хүний нөөцийн ил тод байдал.....	25
3.3 Төсөв санхүүгийн ил тод байдал	27
3.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал	29
4 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	31
4.1 Үйл ажиллагааны ил тод байдал.....	33
4.1.1 Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл.....	34
4.2 Хүний нөөцийн ил тод байдал.....	34
4.3 Төсөв санхүүгийн ил тод байдал	35
4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал	37
5 ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	40
5.1 Үйл ажиллагааны ил тод байдал.....	42
5.1.1 Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл.....	42

5.2	Хүний нөөцийн ил тод байдал.....	43
5.3	Төсөв санхүүгийн ил тод байдал	44
5.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	46
6	АЙМГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ	48
6.1	Үйл ажиллагааны ил тод байдал.....	50
6.2	Хүний нөөцийн ил тод байдал.....	52
6.3	Төсөв санхүүгийн ил тод байдал	53
6.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	55
7	УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ	58
7.1	Үйл ажиллагааны ил тод байдал.....	60
7.2	Хүний нөөцийн ил тод байдал.....	61
7.3	Төсөв санхүүгийн ил тод байдал	62
7.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	63
8	ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ.....	64
8.1	Үйл ажиллагааны ил тод байдал.....	66
8.2	Хүний нөөцийн ил тод байдал.....	67
8.3	Төсөв санхүүгийн ил тод байдал	68
8.4	Худалдан авах ажиллагааны ил тод байдал	69
9	Хавсралт.....	72
9.1	Үндсэн ойлголтууд.....	72
9.2	Хавсралт 2. арга зүйн тайлбар	73
9.3	Хавсралт 3. судалгаанд хамруулсан Цахим хуудсууд	74
9.4	Хавсралт 4. Цахим хуудсуудын эрэмбэлэлт	77

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧИЛСОН НЭРС

Монгол Улсын яам

БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
СЯ	Сангийн яам
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
УУЯ	Уул уурхайн яам
ССАЖЯ	Соёл, спорт, аялал жуулчлалын яам

Хэрэгжүүлэгч агентлаг

АМГ	Ашигт малтмалын газар
АЕГ	Архивын ерөнхий газар
ГТГ	Газрын тосны газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ИХШХЕГ	Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар
ХОГ	Хөрөнгө оруулалтын газар
ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МЭҮГ	Мал эмнэлэг, үржлийн газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ОӨГ	Оюуны өмчийн газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
НХҮЕГ	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Тохируулагч агентлаг

МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦЭГ	Цөмийн энергийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб

Парламентийн харьяа байгууллагууд

ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
УИХ	Монгол Улсын Их Хурал

Улаанбаатар хотын засаг захиргаа

НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
-------	--------------------------------------

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин.....	16
Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь).....	22
Хүснэгт 3. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь).....	23
Хүснэгт 4. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 яам (хувь).....	27
Хүснэгт 5. ХАА-ны ил тод байдал ТОП 3 яам (хувь).....	29
Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	31
Хүснэгт 7. ТОП 5 үзүүлэлттэй хэрэгжүүлэгч агентлагууд (хувь).....	32
Хүснэгт 8. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээТОП 3 (хувь).....	36
Хүснэгт 9. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	40
Хүснэгт 10. ТОП 5 үзүүлэлттэй тохируулагч агентлагууд (хувь).....	41
Хүснэгт 11. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь).....	45
Хүснэгт 12. Аймгуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)	48
Хүснэгт 13. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь).....	49
Хүснэгт 14. Хүний нөөцийн ил тод байдал ТОП 3 аймаг (хувь).....	52
Хүснэгт 15. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 аймаг (хувь).....	54
Хүснэгт 16. ХАА-ны ил тод байдал ТОП 3 аймаг (хувь).....	56
Хүснэгт 17. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)	58
Хүснэгт 18. Нийслэлийн захиргаа, дүүргийн ТОП 5 байгууллага	59
Хүснэгт 19. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 дүүрэг (хувь)	61
Хүснэгт 20. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 нийслэл, дүүрэг(хувь)	62
Хүснэгт 21. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал ТОП 2 (хувь)	63
Хүснэгт 22. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)	64
Хүснэгт 23. ПХБ-ын хүний нөөцийн ил тод байдал ТОП 2 (хувь)	68
Хүснэгт 24. Төсөв, санхүүгийн ил тод байдал ТОП 3 (хувь)	69
Хүснэгт 25. ПХБ-уудын ХАА-ны ил тод байдлын үнэлгээ ТОП 3 (хувь)	70
Хүснэгт 26. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд.....	73
Хүснэгт 27. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ	74

ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Шалгуур үзүүлэлт түс бүрийн үнэлгээний системд эзлэх хувь	15
Дүрс 2. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал	17
Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал	18
Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал	18
Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал	19
Дүрс 6. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал	20
Дүрс 7. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал	20
Дүрс 9. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувь)	23
Дүрс 10. Яамдын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	23
Дүрс 11. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)	24
Дүрс 12. Яамдын цахим хуудас дахь байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	25
Дүрс 13. Яамдын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	25
Дүрс 14. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	27
Дүрс 15. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	28
Дүрс 16. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)	29
Дүрс 17. Яамдын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт (хувь)	30
Дүрс 18. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)	32
Дүрс 19. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	33
Дүрс 20. Хэрэгжүүлэгч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)	33
Дүрс 21. Хэрэгжүүлэгч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	34
Дүрс 22. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	35
Дүрс 23. Хэрэгжүүлэгч агентлагын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	36
Дүрс 24. Хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)	37
Дүрс 25. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)	38
Дүрс 26. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	39
Дүрс 27. Тохируулагч агентлагуудын ил тод байдал (хувь)	41
Дүрс 28. Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	41
Дүрс 29. Тохируулагч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)	42
Дүрс 30. Тохируулагч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	43
Дүрс 31. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	43
Дүрс 32. Тохируулагч агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	44
Дүрс 33. Тохируулагч агентлагуудын санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)	46
Дүрс 34. Тохируулагч агентлагуудын ХАА-ны ил тод байдал (хувь)	46
Дүрс 35. Тохируулагч агентлагуудын ХАА-ны ил тод байдал (хувь)	47
Дүрс 36. Аймгуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)	49
Дүрс 37. Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	50
Дүрс 38. Аймгуудын ерөнхий мэдээлэл (хувь)	50
Дүрс 39. Аймгуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)	51
Дүрс 40. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)	52
Дүрс 41. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	53

Дүрс 42. Хөвсгөл аймгийн цахим хуудас дахь төсөв, санхүүгийн мэдээлэл.....	54
Дүрс 43. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь).....	55
Дүрс 44. Аймгуудын цахим хуудасны ХАА-ны ил тод байдал (хувь).....	55
Дүрс 45. Аймгуудын ХАА-ны ил тод байдал (хувь).....	56
Дүрс 46. НЗДТГ-ын цахим хуудасны үнэлгээнд гарсан өөрчлөлт(хувь)	59
Дүрс 47. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)	59
Дүрс 48. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)	60
Дүрс 49. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн олон нийттэй харилцахтай холбоотой мэдээлэл (хувь).....	60
Дүрс 50. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)	61
Дүрс 51. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)	62
Дүрс 52. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)	63
Дүрс 53. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдал (%)	64
Дүрс 54. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)	65
Дүрс 55. Парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны хэрэглэх байдал (хувь)	65
Дүрс 56. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь).....	66
Дүрс 57. Парламентын харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь).....	67
Дүрс 58. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)	67
Дүрс 59. Парламентын харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь).....	68
Дүрс 60. ХАА-ны ил тод байдал (хувь).....	70

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. БШУЯ-ны хүний нөөцийн мэдээлэл	26
Зураг 2. ЭХЯ-ны хүний нөөцийн мэдээлэл.....	26
Зураг 3. ЭЗХЯ-ны төсөв, санхүүгийн мэдээлэл	28
Зураг 4. Хөдөлмөрийн яамны ХАА-ны талаарх мэдээлэл	30
Зураг 5. ХААГ-ын хүний нөөцийн мэдээлэл	35
Зураг 6. ШШГЕГ-ын төсөв, санхүүгийн мэдээлэл	36
Зураг 7. Ашигт малтмалын газрын цахим хуудас дахь ХАА-ны талаарх мэдээлэл	38
Зураг 8. МХЕГ-ын хүний нөөцийн мэдээлэл.....	44
Зураг 9. МХЕГ-ын цахим хуудас дахь төсөв, санхүүгийн мэдээлэл	45
Зураг 10. Төрийн өмчийн хорооны ХАА-ны талаарх мэдээлэл.....	47
Зураг 11. Аймгуудын ил тод байдлын үзүүлэлт	48
Зураг 12. Баян-Өлгий аймгийн цахим хуудас дахь хүний нөөцийн мэдээлэл.....	53
Зураг 13. Баянхонгор аймгийн цахим хуудас дахь ХАА-ны талаарх мэдээлэл.....	56
Зураг 14. Дүүргүүдийн ил тод байдлын үзүүлэлт	58
Зураг 15. БХД-ийн хүний нөөцийн ил тод байдал	61
Зураг 16. БГД-ийн төсөв, санхүүгийн ил тод байдал	62
Зураг 17. ЧД-ийн ХАА-ны ил тод байдал	63
Зураг 18. ХЭҮК-ын хүний нөөцийн ил тод байдал	68
Зураг 19. ҮАГ-ын төсөв, санхүүгийн ил тод байдал	69
Зураг 20. СЕХ-ны ХАА-ны ил тод байдал.....	70

ОРШИЛ

Монгол Улсын Засгийн Газрын (МУЗГ) мэдээлэл, харилцаа холбоо, технологийн (МХХТ-ийн) салбарт төрөөс баримтлах дунд хугацааны (2005-2012 он) стратеги, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийг 2004 онд баталсан билээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд “Цахим Засгийн мастер төлөвлөгөө” боловсруулж Монгол улсад цахим засгийг хэрэгжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааг автоматжуулах, иргэндээ хандсан, нэг цэгийн, үр дүнтэй, хэмнэлттэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн.

МУЗГ-аас 2008 онд төрийн удирдлагын ил тод, нээлттэй, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилго бүхий “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг Засгийн газрын 143 дугаар тоот тогтоолоор (цаашид “Тогтоол” гэх) батлан, уг шалгуурыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон байдаг. Уг тогтоолд төрийн байгууллагын ил тод байдлыг хангахдаа байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү болон худалдан авах үйл ажиллагаатай холбоотой тодорхой мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудаст байршуулсан байхаар заасан юм.

Мөн ерөнхийлөгчийн санаачлагаар хийгдэж буй “том төрөөс ухаалаг төр лүү” ажлын хүрээнд хийгдэж буй нэг томоохон ажил нь “Шилэн дансны хууль” батлагдсан явдал юм. Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Том төрөөс ухаалаг төр лүү” үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр тавьсан илтгэлдээ шилэн дансны тухай гол зарчмуудыг тайлбарласан дараах асуудлуудыг тодорхой дурдсан. Тухайлбал, “Шилэн дансны тухай хууль”-ийн талаар ярихдаа:

- 1 сая төгрөгөөс дээших төсөв, мөнгө, хөрөнгийн зарцуулалттай холбоотой бүх шийдвэрийг нээлттэй болгох
- Шийдвэр бүрийг 72 цагт багтаан албан ёсны цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдэгдэх зэргийг чухалчилсан.

Харин “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн талаар ярихдаа, эхнээсээ эцсээ хүртэл олон нийтэд нээлттэй ил тод байх¹ үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатайг дурдсан.

Дээр дурьдсан “Шилэн дансны тухай” хууль энэ оны 7 дугаар сард батлагдсан ба 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхлэх юм. Тиймээс энэхүү цахим хуудасны мониторингийн үнэлгээ цаашид нээлттэй ил тод байдлыг үнэлэх нэгэн гол түлхүүр болно гэж үзэж байна.

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал үнэлгээ” нь анх “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” ЗГ-ын 143 дугаар тогтоолын заалтууд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, дүгнэх зорилгоор 2010 онд IRIM судалгааны хүрээлэн Авилгатай Тэмцэх Газрын (АТГ) захиалга, UNDP-ийн санхүүжилттэйгээр ЗГ-ын байгууллагын цахим хуудаст нээлттэй мэдээллийн мониторинг хийх ажлаар эхэлсэн. Энэ ажлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор АТГ-тай хамтран судалгааны үр дүнг танилцуулах хэд хэдэн уулзалт зохион

1 “Том төрөөс ухаалаг төр лүү” үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр ерөнхийлөгчийн тавьсан илтгэлээс, 2013 оны 11 дүгээр сарын 16

байгуулсан. Үүнийг үргэлжлүүлэн хийх шаардлагаар 2014 оноос өөрсдийн санхүүжилтээр албан ёсны зөвшөөрөлтэй гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээ танилцуулж байна.

2014 оны мониторинг дараах онцлогтой. Үүнд:

1. Мониторингийн судалгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад арга зүйн хувьд өөрчлөгдөөгүй ба судалгааны арга зүйг олон улсын стандартад ойртуулсан анкет байдлаар боловсруулсан. Тиймээс өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулах боломжтой. 2010, 2011 оны судалгаанд мэдээллийн ач холбогдол, найдвартай, цаг үеийн тодорхой байдал зэргээр үнэлж байсан нь заримдаа уншигчдад ойлгомжгүй байсан. Иймээс байгууллагын үндсэн мэдээлэл, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал гэх мэт тодорхой сэдвээр ангилснаар тайланг уншихад илүү хялбар, ойлгомжтой болсон.
2. Өмнөх судалгаанд хамрагдсан байгууллагын төрлүүдэд бага зэрэг өөрчлөлт оруулсан. 2011 оны судалгаанд дүүргүүдийн шүүхийн цахим хуудсыг хамруулж байсан бол энэ удаад нэгдүгээрт, бүтцийн хувьд өөрчлөгдсөн, хоёрдугаарт, бүх иргэдэд үйлчилгээг хүргэх байгууллага биш гэж үзээд хассан. Харин дүүргүүдийн цахим хуудсыг нэмж оруулсан.
3. 2014 оны тайлан өмнөх тайлантай харьцуулахад байгууллагын төрөл тус бүрээр бичигдсэн тул тайлантай танилцагч хэн бүхэн хүссэн төрийн байгууллагынхаа цахим хуудсын үнэлгээг харах бүрэн боломжтой.
4. 2011 онд хийгдсэн судалгаанаас хойш Засгийн газар солигдож, шинэ бүтэц зохион байгуулалтад орсон. Тухайлбал, 2011 онд яамдын тоо 11 байсан бол 16 яамтай байгаа. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулалт хийхэд зарим талаар тохиромжгүй болгож байгааг анхаарах хэрэгтэй.

1 МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

1.1 Мониторингийн зорилго, зорилт

Энэ судалгаа нь төрийн байгууллагуудын цахим хуудаст мониторинг хийж “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд доорх зорилтууд тавьсан:

- Өнгөрсөн удаагийн мониторингийн арга зүйг баримтлах. Ингэх нь харьцуулагдахуйц байдлыг хадгална. Гэхдээ үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал тус бүрээр үнэлэх
- Мониторингийн үр дүнг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэх;
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.

1.2 Мониторингийн хамрах хүрээ

Мониторингийн мэдээллийг 2014 оны 07 сарын 08-аас 2014 оны 7 дугаар сарын 16-нд хийсэн ба энэ хугацаанд ажиллаж байсан нийт 87 байгууллагын цахим хуудсыг хамруулсан. Өмнөх 2011 онд хийгдсэн судалгаанд 100 байгууллага хамрагдаж байсан бол энэ удаа байгууллагын тоо буурсан шалтгаан нь хэрэгжүүлэгч агентлагийн тоо шинэ Засгийн газарт буурсантай холбоотой.

Тодруулбал судалгаанд:

- Монгол улсын яам -16;
- Монгол улсын хэрэгжүүлэгч агентлаг - 18
- Монгол улсын тохируулагч агентлаг -12;
- Монгол улсын орон нутгийн захиргаа- 21;
- Нийслэл, дүүргийн захиргаа - 11
- Улсын Их Хурал болон түүний харъяа байгууллага -9 хамрагдсан.

Энэ удаагийн судалгаанд хамрагдсан байгууллагуудаас Дорнод, Баянхонгор, Орхон аймгийн цахим хуудас 2011 онд нэвтрэх боломжгүй байсан. Мөн Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны цахим хуудас нэвтрэх боломжгүй байсан бол бусад яамдын бүтцэд өөрчлөлт гарснаар харьцуулалт хийх боломж багассан. Хандалт хийхэд нэвтрэх боломжгүй байсан цахим хуудсуудад мэдээлэл цуглуулах хугацаанд өдөр бүр нэвтрэх оролдлого хийж байсан. Үүнтэй зэрэгцэн www.zasag.mn хуудаст хандан тухайн байгууллагын холбоосоор нэвтрэх, www.google.mn хуудаст байгууллагын нэрийг бичин хайлт хийж нэвтрэх оролдлогыг хийж байсан.

1.3 Мониторингийн үзүүлэлтүүд

Уг мониторингийн арга зүйд ашиглагдсан үндсэн үзүүлэлтүүд нь тухайн төрийн байгууллага хэр ил тод байгааг хэмжихэд чиглэгдсэн. Хэдийгээр ил тод байдлыг хэмжих олон янзын үзүүлэлт байдаг ч (тухайлбал улс төрийн, эдийн засгийн, хэвлэл мэдээллийн, хүний эрхийн, бизнесийн өнцгөөс гэх мэт) энэ удаад үндсэн хоёр чиглэлээр шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

1. Тогтоолд тусгасан мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн дөрвөн хүрээ болох “Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал”, “Хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдал”, “Төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдал”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал” гэсэн мэдээллийн хүрээг авч үзсэн.
2. Хоёрдугаарт, улсын болон төрийн байгууллагын цахим хуудаст тавигддаг олон улсын нийтлэг шаардлага, стандарт үзүүлэлтүүдэд тулгуурласан.

Үзүүлэлтүүдийг боловсруулахдаа ХЭМЖИГДЭХҮЙЦ, ХЭРЭГЖИХҮЙЦ, БОДИТОЙ байх зарчмыг баримталсан. Мэдээллийн агуулгын шинжилгээг хийх нийтлэг шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллага ил тод байдлын тодорхойлолтод ашигласан үндсэн гурван үзүүлэлт, НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн Комиссын ашигласан нэг үзүүлэлтийг хослуулснаас гадна ил тод байдлыг гэхээсээ илүүтэй цахим хуудсуудын чанарыг үнэлэхэд өргөн ашигладаг стандарт үзүүлэлтийг нэмж нийт таван үзүүлэлт бүхий дизайн боловсруулсан.

Үзүүлэлт 1. Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance): Төрөөс иргэдэд үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүртэх боломжтой байдал. Нарийвчилбал, тухайн цахим хуудас нь ЗГ-ын 143 дугаар тогтоолд цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуух 28 төрлийн мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ.

Үзүүлэлт 2. Мэдээллийн найдвартай байдал (Reliability): Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг илэрхийлнэ (Alanezi, Kamil, & Basri, 2010). Мөн Тогтоол дахь дөрвөн хүрээний дагуух 28 төрлийн мэдээлэл хэр найдвартай байгааг хэмжинэ.

Үзүүлэлт 3. Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness): Цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг хэмжинэ (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цагаа олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг, уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн авч ашиглах боломжтой эсэхийг хянах юм.

Үзүүлэлт 4. Цахим хуудсуудын хүртээмжтэй байдал (Accessibility): Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагад шүүд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ дээрх гурван шалгуур үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийх юм.

Үзүүлэлт 5. Хэрэглэхэд хялбар байдал Usability): Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэх. Үүнд цахим хуудсуудын туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэт хэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дээрх үндсэн таван үзүүлэлтийн тусламжтайгаар төрийн байгууллага цахим хуудсаараа дамжуулан 143 дугаар тогтоолд заасан үндсэн дөрвөн хүрээний мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгааг хэмжих юм.

Онцлон тэмдэглэхэд, хэдийгээр 143 дугаар тогтоолд заасан мэдээллийн зарим хүрээ, тухайлбал хүний нөөц, төсөв, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл тухайн төрийн байгууллагын албан ёсны цахим хуудаснаас тусдаа нэгдсэн цахим хуудаст байрладаг боловч цахим хуудас бүр дээр эдгээр мэдээллийг тавихад хориглох зүйлгүй гэж үзэн мониторингийн үнэлгээнд хамруулсан болно. Жишээлбэл, аль нэг төрийн байгууллагын цахим хуудаст хүний нөөцийн талаарх мэдээлэл шууд тавигдаагүй боловч энэ талаарх мэдээллийг авч болох холбоос (Төрийн албаны зөвлөлийн холбоос гэх мэт), холбогдох албан тушаалтны хаяг зэрэг багтсан байвал хүний нөөцийн хүрээний мэдээлэл агуулагдсан хэмээн үнэлэх боломжтой. Ингэснээр цахим хуудсуудыг шалгуурын нэгдсэн түвшинд хамруулж олон төрлийн цахим хуудсыг хооронд нь харьцуулах боломжтой болсон.

Мэдээлэлд шинжилгээ хийсэн арга. Хамрагдсан төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр нь эрэмбэлж жагсаалт гаргах нь мониторингийн нэг зорилт юм. Ил тод байдлын хэрэгжилтийг үнэлэхдээ үндсэн гурван хэлбэрээр шинжилгээг гаргасан нь:


Тухайн үзүүлэлтийн хэрэгжилт цахим хуудсуудад ямар түвшинд байгааг хэмжүүр тус бүрээр хувь тооцож үнэлэх

Өмнөх судалгаатай харьцуулагдахуйц байдлаар үзүүлэлтүүдийг харуулах

Байгууллага тус бүрийн үзүүлэлтүүдээс авсан оноо, хувийг эрэмбэлж, хавсралтад харуулах

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ гэдгийг ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг Дүрс 1-д харуулав.

Дүрс 1. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эзлэх хувь



Мэдээллийн холбогдолтой байдал мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлтүүдээс хамгийн өндөр буюу 30%-ийг эзэлж байгаа. Энэ нь цахим хуудаст тогтоолд заасан мэдээллийн бүх хүрээ ямар нэг байдлаар тавигдсан байгааг илтгэнэ. Тиймээс энэ нь ил тод байдлыг үнэлэх хамгийн чухал үзүүлэлт болох юм.

Харин тухайн мэдээлэл нь чанарын хувьд ямар мэдээлэл байна вэ гэдэгтэй холбоотой хоёр үзүүлэлт байгаа бөгөөд нийт үнэлгээний системд тус бүр 20 хувь, нийлээд 40 хувь эзэлнэ (мэдээллийн найдвартай ба цаг үеийн байдлын үзүүлэлтүүд).

Эцэст нь мэдээлэл хэрхэн хүрч байна вэ гэдэгт цахим хуудасны хүртээмжтэй байдал, хэрэглэхэд хялбар байдал багтсан бөгөөд эдгээр нь илүү хэлбэрийн шинжтэй үзүүлэлт тул нийт үнэлгээний системд тус бүр 15 хувь (мэдээллийн хүртээмжтэй байдал ба хэрэглэхэд хялбар байдал), нийт 30 хувийг эзэлж байна.

Мөн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэхдээ өмнөх мониторингийн арга зүйд ашигласан “шалгуурыг хангасан”, “шалгуурыг хангаагүй” гэсэн үнэлгээг нарийвчилсан. Тухайлбал, тухайн үзүүлэлтийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудсуудын үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон утгаар хэмжих оролдлого хийсэн. Хэмжилтээр гарч ирсэн үр дүнг тухайн үзүүлэлт тус бүрээр уг мониторингийн ажилд хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаа вэ гэдгийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1. Тухайн үзүүлэлтийг хангаж буй түвшин

Хувь	Ил тод байдал
81-100	Бүрэн ил тод
61-80	Ил тод
41-60	Зарим талаар ил тод
0-40	Хаалттай


Дээрх таван үзүүлэлт тус бүрийн үнэлгээний түвшний дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 2 хэсгээс харна уу.

2 ГОЛ ҮР ДҮН

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан нийт төрийн байгууллагуудын цахим хуудсуудын дундаж үзүүлэлтийг харьцуулж харуулах болно.

Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын авсан нийт оноог өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулсныг доорх дүрсээс харна уу.

Дүрс 2. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал




Уг дүрсээс харахад, 2011 онд нийт төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал 100 хувиас 28 хувьтай байсан бол энэ жил 36,4 болж 8 пунктээр өссөн байна. Хэдийгээр байгууллагуудын ерөнхий дундаж оноо өссөн ч уг үзүүлэлт нь “хаалттай” /0-40/ гэсэн ангилалд орсон хэвээр байна.

Байгууллага тус бүрийн дундаж оноог авч үзвэл “зарим талаар ил тод” /40-60/ гэсэн ангилалд аймгуудын цахим хуудас орсон байна. Мөн өмнөх судалгааны үр дүнгээс хамгийн их өссөн бүлэг бол аймгуудын цахим хуудас юм. Өмнөх судалгаанд аймгуудын дундаж үзүүлэлт 25,1 хувьтай байсан бол энэ удаад 40,5 хувь болж өсчээ. Харин яамдын цахим хуудсуудын хувьд өмнөх судалгааны үр дүнгээс үл ялиг буурсан буюу 39,1 хувь байснаа 36,7 хувь болжээ. Яамдаас бусад байгууллагын цахим хуудасны ил тод байдал ерөнхийдөө өссөн байна.

2.1 Мэдээллийн хамааралтай байдал

Энэ хэсэгт ЗГ-ын 143 дугаар тогтоолд цахим хуудаст тавигдсан байхаар заасан дөрвөн хүрээний дагуу 28 төрлийн мэдээллийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэхийг хэмжинэ. Ийнхүү хэмжихэд бүх байгууллагын үр дүн 2011 оны үзүүлэлтээс тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна. 2011 онд төрийн байгууллагын 30,2 хувь нь цахим хуудастаа өөрсдийн үйл ажиллагаатай хамааралтай мэдээ мэдээлэл тавьдаг байсан бол энэ онд 40,8 хувь болж 10 пунктээр өссөн байна.

Дүрс 3. Төрийн байгууллагын мэдээллийн хамааралтай байдал



Энэ үзүүлэлт төрийн байгууллагууд нийт тавих ёстой мэдээллийнхээ 36-44 хувийг цахим хуудастаа ил тод тавьж байгааг харуулж байна. Төрийн байгууллагуудыг ангилан авч үзвэл яамдын хувьд хамгийн өндөр буюу 45,8 хувьтай байна. Харин хамгийн муу үзүүлэлттэй байгаа нь нийслэл, дүүргүүдийн цахим хуудас байна.


Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад бүх байгууллагын үр дүн өссөн үзүүлэлттэй байна. Нийслэл, дүүргүүдийн цахим хуудас мэдээллээ ил тод тавих нь өмнөх жилүүдээс бараг хоёр дахин сайжирсан үзүүлэлттэй байна. Харин яамд, агентлагуудын хувьд өмнөх судалгааны үр дүнгээс төдийлөн ахиагүй байна.

2.2 Мэдээллийн найдвартай байдал

Мэдээллийн найдвартай байдал гэдэгт тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэхийг хэмжинэ. Ийнхүү хэмжихдээ байгууллагуудын цахим хуудаст тавьсан мэдээллийн эх сурвалж, нийтэлсэн хүний овог нэр байгаа эсэх зэрэг үзүүлэлтийг авч үзсэн юм.

Уг үзүүлэлтийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад 4 пунктээр өссөн байна. Хэдийгээр нийт үр дүн бага зэрэг өссөн байгаа ч зарим байгууллагын үр дүн өмнөх жилүүдээс хамаагүй буурсан үзүүлэлттэй байна.

Дүрс 4. Төрийн байгууллагын мэдээллийн найдвартай байдал




Дээрх дүрсээс харахад тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд, аймгуудын цахим хуудасны мэдээллийн найдвартай байдал нэмэгдсэн бол яамд, нийслэл, дүүргүүд, парламентийн байгууллагуудын хувьд буурсан байна. Ялангуяа тохируулагч агентлагуудын цахим хуудасны хувьд 2011 онд нийт мэдээллийн 23,1 хувь нь найдвартай байсан бол энэ жил 3,5 хувь болтлоо эрс буурсан байна.

2.3 Мэдээллийн цаг үеийн байдал

Мэдээллийн цаг үеийн байдал гэдэгт төрийн байгууллагууд цахим хуудаст цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэхийг ойлгоно (Harris, 2010). Өөрөөр хэлбэл, төрөөс иргэдэд хүргэж буй мэдээлэл цаг үеэ олсон, тогтмол давтамжтай шинэчлэгддэг бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчид хүлээн ав, ашиглах боломжтой байдлыг бүрдүүлж байгаа эсэхийг энэ үзүүлэлтээр хянах юм.

Судалгааны үр дүнгээс харахад мэдээллийн цаг үеийн байдал өмнөх жилүүдийн үр дүнгээс хавьгүй дээшилсэн байна. 2011 онд төрийн байгууллагуудын тавих ёстой мэдээллийн 7,2 хувь нь цаг үеэ олсон, тохиромжтой цагтаа тавигдсан байсан бол 2014 онд 28,8 хувь болж өсчээ.

Дүрс 5. Төрийн байгууллагын мэдээллийн цаг үеийн байдал




Судалгааны үр дүнгээс харахад бүх төрийн байгууллагын үзүүлэлт тодорхой хэмжээгээр өссөн байна. Мэдээллийн цаг үеийн байдал гэсэн үзүүлэлт хамгийн өндөр нь аймгуудын цахим хуудас байна. 2011 онд аймгуудын цахим хуудаст тавигдсан мэдээллийн 5,9 хувь нь л “цаг үеийн байдал” үзүүлэлтийг хангаж байсан бол энэ удаад 39,8 хувь болж нэмэгджээ. Харин өмнөх судалгааны үр дүнгээр хамгийн өндөр үзүүлэлттэй байсан яамдын хувьд 13,5 хувиас 27 хувь болж нэмэгджээ.

2.4 Мэдээллийн хүртээмжтэй байдал

Энэ үзүүлэлтээр цахим хуудас хэрэглэгчид төрийн байгууллагад шууд хандан зөвлөгөө, мэдээлэл авах боломж олгосон, хоёр талын харилцааг хангахуйц байгаа эсэхийг хэмжинэ (Drew & Nyerges, 2004, p. 57). Ингэхдээ өмнөх гурван үзүүлэлтээс ялгаатай нь мэдээллийн агуулгад бус, цахим хуудаст өөрт нь холбогдох хэмжүүрүүдийн дагуу шинжилгээ хийдэг.

Төрийн байгууллагын цахим хуудасны хүртээмжтэй байдал өмнөх судалгааны үр дүнгээс ялимгүй буурсан үзүүлэлттэй байна. Уг үзүүлэлт 2011 онд 44,9 хувь байсан бол энэ жил 37,8 хувь болж буурчээ.

Дүрс 6. Төрийн байгууллагын мэдээллийн хүртээмжтэй байдал




Уг үзүүлэлтийг бүлэг байгууллагаар авч үзвэл нийслэл, дүүргүүдээс бусад байгууллагын үр дүн өмнөх судалгааныхаасээс буурсан байна. Харин нийслэл, дүүргүүдийн цахим хуудын хүртээмжтэй байдал 2011 онд 20 хувь байсан бол энэ жил 32,7 хувьд өсчээ.

2.5 Цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал

Хэрэглэгчид тухайн цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байгаа эсэхийг мөн хэмжсэн. Үүнд цахим хуудасны туслах хэрэгслүүд, үзэмж, төрх, дизайн зэрэг багтана (Weakley, 2004). Аливаа цахим хуудас нь иргэдийн интернэтхэрэглэх чадварт нийцсэн, энгийн, ойлгомжтой байх нь хэрэглэхэд хялбар байдлыг илтгэх чухал үзүүлэлт болдог.

Дүрс 7. Төрийн байгууллагын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал



Уг үзүүлэлтийг байгууллагын төрөл тус бүрээр харвал хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагуудын хувьд өмнөх судалгааны үр дүнгээс буурсан үзүүлэлттэй байна. Харин яамдын хувьд цахим

хуудасны хэрэглэхэд хялбар байдал төдийлөн нэмэгдээгүй байна. Парламентаас байгуулдаг байгууллагууд болон нийслэл, дүүргүүдийн цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал өмнөх судалгааны үр дүнгээс 20-30 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Судалгааны үр дүнгээс харахад төрийн байгууллагуудын цахим хуудасны 66,8 хувь нь иргэд ашиглахад хялбар байна. Энэ үр дүн 2011 онд 59,8 хувь байсан юм.

3 ЯАМДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 16 яамны албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Яамдын цахим хуудсыг таван үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 2. Яамдын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Яам	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2011	2014	2011	2014
1	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	40,65 ²	32,1	9	50
2	Батлан хамгаалахын яам	33,4	33,1	24	45
3	Барилга, хот байгуулалтын яам		38,5		34
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	46	43,3	4	22
5	Гадаад харилцааны яам	27	27,8	47	60
6	Хууль зүйн яам	- ³	25,8	-	63
7	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	63,1	35,9	1	39
8	Сангийн яам	47,2	39,2	3	31
9	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	31,6	37,1	31	37
10	Эрүүл мэндийн яам	25,1	24,4	53	65
11	Эрчим хүчний яам		45,5		17
12	Зам тээврийн яам		46,1		16
13	Хөдөлмөрийн яам	-	48,2	-	12
14	Эдийн засгийн хөгжлийн яам	-	38,9	-	33
15	Уул уурхайн яам		40,7		28
16	Соёл, спорт, аялал жуулчлалын яам		31,1		53
Яамдын дундаж		39,2	36,7		
Ерөнхий дундаж		28,7	36,9		

Яамдын дундаж үзүүлэлт 2014 оны нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлттэй ижил байгаа боловч 2011 оны дундаж үзүүлэлтээс даруй 8 хувиар өндөр байна. Харин 2011 оны судалгааны яамдын дундаж үзүүлэлттэй харьцуулахад үл ялиг буурсан байна.

Нийт яамдын нийлбэр үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад нэлээд хэмжээгээр буурсан байна. Ялангуяа 2011 онд эхний 10 байранд жагсаж байсан тухайн үеийн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны үнэлгээ эрс буурчээ.


2014 оны байдлаар яамдын дундаас хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь 48,2 хувиар Хөдөлмөрийн яам шалгарсан. Энэ нь нийт судалгаанд хамрагдсан байгууллагаас 12 дугаар байранд жагсаж байгаа юм. 2011 онд Хөдөлмөрийн яам нь Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам байсан тул тухайн үеийн яамны үзүүлэлттэй шууд харьцуулж харах боломжгүй. Хуучнаар Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам 2011 онд 1 дүгээр байранд жагссан үзүүлэлттэй байсан бол одоогоор Хүн ам хөгжил, нийгмийн хамгааллын яам 39 дүгээр байр хүртэл ухарсан.

2 Хуучнаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам

3 Тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас ажиллагаагүй байсан

Цахим хуудасны мониторингийн үр дүнг таван үзүүлэлт тус бүрээр, хоёр оноор харьцуулсан үр дүнг дараах графикт харууллаа.

Дүрс 8. Яамдын цахим хуудасны ил тод байдал (хувь)




2014 онд 5 үзүүлэлтийн 3 нь дээшилсэн бол мэдээллийн найдвартай байдал ба мэдээллийн хүртээмжтэй байдал бага зэрэг бүүрчээ.

Хүснэгт 3. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь)

Яамдын нэрс	Нийлбэр оноо	
	2011	2014
Хөдөлмөрийн яам		48,2
Зам тээврийн яам		46,1
Эрчим хүчний яам		45,5
Боловсрол, шинжлэх ухааны яам	46	43,3
Уул уурхайн яам		40,7

Мэдээллийн хүртээмжтэй байдлыг 5 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд хэлний сонголт болон асуулт хариулт, хэлэлцүүлгийн булан аймгийн цахим хуудсуудад маш хангалтгүй байна. Харин бусад холбогдох байгууллагын холбоосыг байршуулсан нь харьцангуй дээр байгаа ч сүүлийн гурван жилд сайжирсангүй.

Дүрс 9. Яамдын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



Яамдын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлыг үнэлэхэд цахим хуудасны асуулт хариулт, хэлэлцүүлгийн булан, хэлний сонголт зэргийг багтаасан хүртээмжтэй байдлын үзүүлэлт нэлээд буурсан байна. Харин өнгө, үсгийн фонд, хэвлэх, илгээх, файл хадгалах зэрэг үзүүлэлтүүдийг багтаасан хялбар байдлын үзүүлэлт ялимгүй дээшилжээ.

Үүнээс дүгнэхэд, цахим хуудасны хүртээмжтэй байдал 2011 онд зарим талаар хүртээмжтэй гэсэн ангилалд багтаж байсан бол 2014 онд үзүүлэлт доошилсноор хүртээмжгүй гэсэн ангилалд багтаж байна.


Харин цахим хуудсыг хэрэглэхэд хялбар байдал нь хэрэглэхэд боломжтой гэсэн ангилалд байсан хэвээр байна.

3.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Яамдын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан яамдын үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс буусан байдалтай байна.

Дүрс 10. Яамдын ерөнхий мэдээлэл (хувь)



Дээрх дүрсээс харахад яамдын хувьд үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, албан хаагчийн ёс зүйн дүрэм зэрэг мэдээллийн ил тод байдал буурсан нь харагдаж байна. Дээрх байгууллагын ерөнхий мэдээллүүдийг цахим хуудастаа ил байрлуулах байдал нь өмнөх жилүүдээс нэмэгдээгүй байна.


3.1.1 Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл.

Байгууллагын олон нийттэй харьцах мэдээллийг дараах дүрсэд үзүүлсэн 7 үзүүлэлтээр хэмжсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад яамдууд холбоо барих мэдээллүүд болох утасны дугаар, хаяг, факсын дугаар зэрэг мэдээллүүдээ цахим хуудастаа байршуулах байдал нэмэгдсэн байна.

Харин олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэрийг байршуулсан байдал 2011 онд 50 хувьтай байсан бол энэ удаад 6,2 хувь болтол буурсан байна. Энэ нь нийт 16 яамны 1 нь л энэ мэдээллийг байршуулсан байна гэсэн үг юм.

Мөн тухайн цахим хуудаснаас шууд яамны мэргэжилтэнтэй холбогдох боломж 2011 онд 40 хувьтай буюу 10 яамны 4 нь байсан бол энэ удаад нэг ч яамны цахим хуудас ийм боломжийг иргэдэд олгоогүй байна.

Дүрс 11. Яамдын цахим хуудас дахь байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)




Ерөнхийд нь дүгнэхэд яамдын үйл ажиллагааны ил тод байдал 2011 онд 62 хувьтай байсан бол 2014 онд 53,3 хувь болж 9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

3.2 Хүний нөөцийн ил тод байдал

Яамдын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт өмнөх судалгааны үр дүнгээс буурсан үзүүлэлттэй байна. 2011 оны байдлаар яамдын хүний нөөцийн ил тод байдал 28,6 хувьтай байсан бол 2014 онд 10,7 хувьтай болсон нь бараг 2 дахин буурсан үзүүлэлт юм.


Дүрс 12. Яамдын хүний нөөцийн ил тод байдал (хувь)



Ихэнх яамны хувьд байгууллагын сул орон тооны зарыг цахим хуудас дээрээ байрлуулаагүй байв. Хэрэв байрлуулсан тохиолдолд энэхүү мэдээлэл нь хуучирсан байдалтай байна. Жишээлбэл 2014

оны байдлаар хүний нөөцийн ил тод байдлыг хангаж сул орон тооны зараа тавьсан хоёрхон яам байна.

Зураг 1. БШУЯ-ны хүний нөөцийн мэдээлэл



Боловсрол, шинжлэх ухааны яамны хувьд цахим хуудсандаа хүний нөөцийн ил тод байдал гэсэн тусдаа цэс байрлуулсан ба түүн дотроо нээлттэй ажлын байрны заруудыг ил тавьсан байна. Эдгээр зар нь мэдээллийн найдвартай байдлын үзүүлэлтийг хангахгүй байгаа ч цаг хугацааны хувьд тохирсон байдал гэсэн үзүүлэлтийг хангаж байв.

Зураг 2. ЭХЯ-ны хүний нөөцийн мэдээлэл




Харин дээрх зурагт харуулснаар Эрчим хүчний яамны цахим хуудаст байршуулсан хүний нөөцийн мэдээллийг харахад цаг хугацааны хувьд хуучирсан буюу 2013 оны 1 сард тавигдсан мэдээлэл байна. Тухайн мэдээллийг олон нийтэд ил тод болгож байгаа хэдий ч цаг хугацааны хувьд хоцрогдсон мэдээлэл зарим байгууллага тавьж байгаа нь харагдаж байна.

3.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Яамдын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг авч үзэхэд өмнөх судалгааны үр дүнгээс сайжирчээ. Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

Дүрс 13. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Дээрх дүрсээс харахад төсөв санхүүгийн ил тод байдал өмнөх судалгааны үр дүнгээс дунджаар хоёр дахин буюу 16,4 хувь байснаас 28,8 хувь болж өссөн байна. Энэхүү үнэлгээний задаргаанаас харвал төсөв санхүүгийн мэдээллийг ил байрлуулах явдал 2011 онд 10,2 хувьтай байсан бол энэ оны байдлаар 19,4 хувь болж нэмэгдсэн байна. Мөн эдгээр мэдээллийн цаг хугацааны хувьд тохиромжтой байдал нь өмнөх судалгааны дүнгээс мөн өссөн үзүүлэлт болжээ. Харин мэдээллийн найдвартай байдал буюу эх сурвалжийн тодорхой байдал энэ удаад 2011 оны судалгааны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна.

Яамд	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
ЭЗХЯ	-	32,1	-	0	-	20,8	0	52,9
УУЯ	-	32,1	-	0	0	13	0	45,1
ҮХААЯ	0	26,8	0	0	0	13	11,5	39,8

Хүснэгт 4. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 яам (хувь)

Яамд тус бүрээр үзүүлэлтийг харвал нийт 16 яамны 14 яам нь цахим хуудастаа төсөв санхүүгийн мэдээллийг тодорхой хэмжээгээр байршуулсан байна. Харин эдгээр яамдаас хамгийн өндөр оноо авсан эхний гурван яамны хувьд Эдийн засгийн хөгжлийн яам 52,9 хувь, Уул уурхайн яам 45,1 хувь, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам 39,8 хувь нар байна. Уг яамд нь 2012 онд шинэ бүтэц, зохион байгуулалтад орсон яамд тул өмнөх судалгааны үр дүнгүүдтэй харьцуулж, сайжирсан эсэх талаар үнэлэх боломжгүй байна.

Зураг 3. ЭЗХЯ-ны төсөв, санхүүгийн мэдээлэл



Эдгээр яамдаас төсөв санхүүгийн мэдээлэл огт оруулаагүй яамд байсан бөгөөд үүнд Хууль зүйн яам болон Соёл, урлаг, аялал жуулчлалын яам багтаж байна.

Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 8 үзүүлэлтээс 6 үзүүлэлт нь өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа байгууллагын тухайн жилийн төсөв, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн биелэлт, төлбөр хураамжийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс дор хаяж хоёр дахин нэмэгджээ.

Дүрс 14. Яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Харин төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлт, төсвийн төсөл зэрэг мэдээллийг яамдууд өмнөх онуудтай ижил маш хангалтгүй түвшинд мэдээллэсэн хэвээр байна.

Хэдийгээр яамдын төсөв санхүүгийн ил тод байдлын оноо тодорхой хэмжээгээр дээшилсэн хэдий ч хаалттай гэсэн ангиллаас гарах хэмжээнд хүрэхгүй байна.

3.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Яамдын хувьд ХАА-ны тухай мэдээлэл буюу тендэртэй холбоотой баримт бичгийг цахим хуудастаа цаг тухай бүрт нь байршуулах ёстой юм. Доорх дүрсээс харахад 2011 оны хувьд яамдын ХАА-ны ил тод байдал 20,5 хувьтай байсан сүүлийн судалгааны дүнгээр 18,8 хувь болж үл ялиг буурсан байна. Нарийчилсан үзүүлэлтээс харахад ХАА-ны талаарх мэдээллийн найдвартай байдал буюу эх сурвалж тодорхой байдал өмнөх үр дүнгээс багасчээ.

Дүрс 15. Яамдын ХАА-ны ил тод байдал (хувь)




Нийт судалгаанд хамрагдсан яамдаас хамгийн өндөр оноо авсан яамд гэвэл Хөдөлмөрийн яам (71,4%), Зам тээврийн яам (49,3), Батлан хамгаалахын яам (41,4%) байна. Эдгээр яамдаас өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулагдах боломжтой нь Батлан хамгаалах яам бөгөөд 0 оноотой байснаас 41,4 оноо авч зарим талаар ил тод байгууллагын тоонд орж ахисан байна.

Яамд	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
ХЯ	-	42,8	-	0	-	28,6	-	71,4
ЗТЯ	-	32,1	-	0	-	17,2	-	49,3
БХЯ	0	21,4	0	14,3	0	5,7	0	41,4


Хүснэгт 5. ХАА-ны ил тод байдал ТОП 3 яам (хувь)

Зураг 4. Хөдөлмөрийн яамны ХАА-ны талаарх мэдээлэл



Нийт 16 яамны 50 хувь нь буюу найм нь ХАА-ны талаарх мэдээллийг ямар нэгэн байдлаар цахим хуудастаа ил тод байршуулсан байна. Мөн доорх дүрсээс харахад өмнөх жилийн судалгааны үр дүнгээс төдийлэн дээшлээгүй ч гэсэн ХАА-нд хийсэн аудитын дүгнэлт, тайланг цахим хуудастаа байршуулах байдал нь нэмэгджээ. Харин эсрэгээрээ худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлангаа тавих байдал нь буурсан байна.

Дүрс 16. Яамдын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлт (хувь)



4 ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 18 хэрэгжүүлэгч агентлагуудын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 6. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Нэрс	Нийлбэр оноо			Эрэмбэ /Ранк/		
		2011	2014	2015	2011	2014	2015
1	Ашигт малтмалын газар	23,1	47,2	52	60	15	45
2	Архивын ерөнхий газар	34,3	39	50.1	21	32	49
3	Газрын тосны газар	29,9	16,3	46.1	38	75	64
4	Гаалийн ерөнхий газар	32,4	43,4	54.9	27	21	35
5	Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	36,2 ⁴	45,1	41.2	15	19	74
6	Хөрөнгө оруулалтын газар	28,6 ⁵	16,8	34	44	74	80
7	Газрын харилцаа, барилга геодези, зураг зүйн газар	24,4	17,4	40.3	57	73	75
8	Иргэний нисэхийн ерөнхий газар	31,5	32,8	31.7	32	47	82
9	Мал эмнэлэг үржлийн газар	31,8	30,4	48.8	29	57	52
10	Нийгмийн даатгалын ерөнхий газар	38	30,9	45.3	12	54	67
11	Оюуны өмчийн газар	28,9	20,4	34.5	43	71	79
12	Татварын ерөнхий газар	35,9	58,6	47	17	2	61
13	Худалдан авах ажиллагааны газар	-	43,7	52.7	-	20	41
14	Улсын бүртгэлийн ерөнхий газар	33,9	49,4	56.6	23	10	26
15	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	43,9 ⁶	37,3	43.4	5	36	73
16	Хүүхдийн төлөө үндэсний газар	35,8	30	48.2	18	58	55
17	Цаг уур орчны шинжилгээний газар	49	47,9	18.2	2	14	84
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	29,7	48,4	52.3	39	11	42
Хэрэгжүүлэгч агентлагийн дундаж		30,1	36,4	44.5			
Ерөнхий дундаж		28,7	36,9	52.2			

Хэрэгжүүлэгч агентлагуудын дундаж үзүүлэлт 2014 оны хувьд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлттэй ижил түвшинд байна. Харин 2011 оны судалгааны дундаж үзүүлэлтээс 6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 18 агентлагаас 8 агентлагийнх нь нийлбэр оноо өмнөх судалгааны үр

4 Хуучнаар Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх газар

5 Хуучнаар Гадаадын хөрөнгө оруулалтын газар


6 Хуучнаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

дүнгээс тодорхой хэмжээгээр өсчээ. Харин 6 агентлагийн нийлбэр оноо өмнөх үр дүнгээс дунджаар 10 гаруй пунктээр буурсан байна.

Өмнөх судалгааны үр дүнгээр хангалтгүй оноо авч сүүлийн байруудад жагсаж байсан байгууллагууд тодорхой хэмжээний ахиц гаргаж энэ удаагийн судалгаагаар дээгүүр жагсчээ. Жишээлбэл: Ашигт малтмалын газрын цахим хуудас 2011 онд 23,1 оноо авч 60 дугаар байранд жагсаж байсан бол энэ удаа 47,2 оноо авч 15 дугаар байранд оржээ. Мөн Татварын ерөнхий газрын цахим хуудас 2011 онд 35,9 оноо авч 17 дугаар байранд байсан бол энэ удаад 58,6 оноо авч 2 дугаар байранд жагссан байна. Үүнээс харахад уг байгууллагууд иргэдэд мэдээллээ ил тод нээлттэй болгох тодорхой алхмуудыг авч түүнийх нь үр дүн гарч байгаа нь харагдаж байна. Гэвч хамгийн сайн үзүүлэлттэй агентлагууд 60-аас дээш оноо авч ил тод гэсэн ангилалд хараахан орж чадахгүй зарим талаар ил тод гэсэн ангилалд багтаж байна.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу хоёр оноор харьцуулан гаргаж өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа.

Дүрс 17. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)




2014 онд 5 үзүүлэлтийн 2 нь болох мэдээллийн найдвартай байдал, цаг үеийн байдал дээшилсэн бол бусад үзүүлэлтүүд ерөнхийдөө өмнөх судалгааны үр дүнтэй ижил түвшинд байна.

Хүснэгт 7. ТОП 5 үзүүлэлттэй хэрэгжүүлэгч агентлагууд (хувь)

Хэрэгжүүлэгч агентлагуудын нэрс	Нийлбэр оноо		
	2011	2014	2015
Улсын бүртгэлийн ерөнхий газар	33,9	49,4	56,5
Гаалийн ерөнхий газар	-	-	54,8
Худалдан авах ажиллагааны газар	-	-	52,7
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	29,7	48,4	52,3
Ашигт малтмалын газар	23,1	47,2	51,9

Дүрс 18. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны хүртээмжтэй байдал нь сүүлийн 3 жилийн хугацаанд 7,7 хувиар буурсан байгаа бол хэрэглэхэд хялбар байдал нь 12,9 хувиар бүүрчээ. Үүнээс дүгнэвэл цахим хуудасны хүртээмжтэй байдал нь зарим талаар хүртээмжтэй гэсэн ангилалд хэвээр байхад хэрэглэхэд хялбар байдлын үзүүлэлт нь хэрэглэхэд боломжтой гэсэн ангилалаас бүүрч хэрэглэхэд төвөгтэй гэсэн ангилалд оржээ.

4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал төдийлэн дээшлээгүй байна.

Дүрс 19. Хэрэгжүүлэгч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)



Дээрх үр дүнгээс харахад байгууллагууд тэргүүлэх чиглэлээ цахим хуудас дээрээ байршуулах байдал нь өмнөх судалгааны үр дүнгээс бүүрч 0 хувьтай болсон байна. Харин албан хаагчийн ёс зүйн дүрэм,

байгууллагын эрхэм зорилгоо тавих байдалд төдийлөн ялгаа гараагүй бол үйл ажиллагааны стратеги зорилтыг байршуулах байдал нь 20 гаруй пунктээр нэмэгджээ.


4.1.1 Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл.

Байгууллагын олон нийттэй харьцах мэдээллийг дараах дүрсэд үзүүлсэн 7 үзүүлэлтээр хэмжсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад холбоо барих мэдээллүүд болох утасны дугаар, хаяг, факсын дугаар зэрэг мэдээллүүд өмнөх судалгааны үр дүнгүүдтэй бараг ижил түвшинд байна.

Харин олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэрийг байршуулсан байдал 2011 онд 65,6 хувьтай байсан бол энэ удаад 11,1 хувь болтол буурсан байна. Мөн шуудангийн хаягаа бичсэн байдал 34,4 хувиас 5,6 хувь болтол буурчээ.

Тухайн цахим хуудаснаас шууд агентлагийн мэргэжилтэнтэй холбогдох боломж 2011 онд 18,8 хувьтай байсан бол энэ удаад нэг ч хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудас ийм боломжийг иргэдэд олгоогүй байна.

Дүрс 20. Хэрэгжүүлэгч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)




Ерөнхийд нь дүгнэхэд хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны ил тод байдал 2011 онд 59,8 хувьтай байсан бол 2014 онд 51,1 хувь болж 8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

4.2 Хүний нөөцийн ил тод байдал


Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. 2011 оны байдлаар хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал 9,4 хувьтай байсан бол 2014 онд 24,6 хувьтай болсон нь бараг 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Дүрс 21. Хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)



2011 оны байдлаар нийт агентлагууд сул орон тооны талаарх мэдээллээ дөнгөж 4 хувьтай ил тод байршуулж байсан бол энэ оны байдлаар 11,9 хувь болж өссөн байна. Мөн тухайн мэдээллийн цаг хугацааны хувьд шинэлэг байх байдал нь тодорхой хувиар дээшилсэн байна.

Зураг 5. ХААГ-ын хүний нөөцийн мэдээлэл




Худалдан авах ажиллагааны газрын хувьд цахим хуудасандаа хүний нөөцийн ил тод байдал гэсэн тусдаа цэс байрлуулсан ба дотор нь нээлттэй ажлын байрны заруудыг олон нийтэд ил тавьсан байна. Эдгээр зар нь мэдээллийн найдвартай байдлын шалгуурыг хангахгүй байгаа хэдий ч цаг хугацааны хувьд тохирсон байдал гэсэн шалгуурыг хангаж байв.

4.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг авч үзэхэд өмнөх судалгааны үр дүнгээс хамаагүй сайжирсан байдалтай байна. Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

Дүрс 22. Хэрэгжүүлэгч агентлагын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Дээрх дүрсээс харахад төсөв санхүүгийн ил тод байдал 2011 оны судалгааны үр дүнгээр 3,7 хувь байсан бол 2014 оны судалгаагаар 28,1 хувь болж 24 пунктээр өсчээ. Хэрэгжүүлэгч агентлагууд төсөв санхүүтэй холбоотой мэдээллээ цахим хуудастаа байршуулах байдал 2,2 хувь байснаас 13,4 хувь болж өссөн бол мэдээллийн эх сурвалж тодорхой байдал болон цаг хугацааны хувьд тохирсон байдал нь мөн адил өсчээ.

Хүснэгт 8. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээТОП 3 (хувь)

Агентлаг	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
ШШГЕГ	0	26,8	0	17,9	0	16,9	0	61,5
УБЕГ	0	26,8	0	17,9	0	13	0	57,6
ТЕГ	5,4	16,7	3,6	10,7	10,3	11,7	10,2	38,5

Агентлаг тус бүрээр үзүүлэлтийг харвал нийт 18 агентлагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 61,5 хувь, Улсын бүртгэлийн ерөнхий газар 57,6 хувь, Татварын ерөнхий газар 38,5 хувиар хамгийн өндөр оноо авч эхний 3 байранд орсон байна. Эдгээр эхний 2 агентлаг нь өмнөх судалгааны явцад 0 хувьтай байсан буюу төсөв санхүүгийн мэдээллээ цахим хуудастаа байршуулдаггүй байжээ.

Зураг 6. ШШГЕГ-ын төсөв, санхүүгийн мэдээлэл



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ЭХЛЭЛ | ТАНИЛЦУУГА | ГАЗАР НЭГЖ | МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ | ГАДААД ХАРИЛЦАА | ХУУЛЬ ТОГТООМЖ | **САНХҮУ** | СУРГАЛТ | ХҮНИЙ НӨВЦ | ИРГЭДЭД

Санхүүгийн тайлан

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2014 эхний хагас жилийн санхүүгийн тайлан

2 өдөр өмнө


33 хуульчилсан тогтоолын маргааныг эзэмшүүлж байна

3 өдөр өмнө

Төсөв санхүүгийн ил тод байдлаар нэг дүгээр байранд орсон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын цахим хуудаснаас харахад тавьсан мэдээллүүд нь цаг хугацааны хувьд тохиромжтой буюу шинэлэг байж чадаж байна.

Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 8 үзүүлэлтээс 7 үзүүлэлт нь өмнөх судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа байгууллагын тухайн жилийн төсөв, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн биелэлт зэрэг үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс дор хаяж хоёр дахин нэмэгдсэн байна.

Дүрс 23. Хэрэгжүүлэгч агентлагийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлт (хувь)




Харин хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээний ил тод байдал өмнөх судалгаагаар 15,6 хувьтай байсан бол энэ онд 0 хувь болж буурчээ.

4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Хэрэгжүүлэгч агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудастаа ил тод байршуулах байдал мөн өмнөх судалгааны үр дүнгээс нэмэгдсэн байдалтай байна. 2011 оны байдлаар 12,6 хувьтай байсан бол энэ удаагийн судалгаагаар 25,9 хувь болж даруй 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Нарийвчилсан үзүүлэлтүүдээс харвал бүх үзүүлэлтүүд жигд өссөн байна. Тухайлбал ХАА-ны талаарх мэдээллийг байршуулсан байдал 6 хувиас 11,9 хувь болж, эх сурвалж тодорхой байдал 3,6


хувиас 7,9 хувь болж, цаг хугацааны хувь тохиромжтой байдал 3 хувиас 6 хувь болж тус тус 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дүрс 24. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдал (хувь)




Нийт судалгаанд хамрагдсан агентлагуудаас 5 агентлаг нь 47,1 хувийн үзүүлэлттэй гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна. Эдгээр нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын ерөнхий газар, Цаг уур орчны шинжилгээний газар, Худалдан авах ажиллагааны газар зэрэг байв.

Зураг 7. Ашигт малтмалын газрын цахим хуудас дахь ХАА-ны талаарх мэдээлэл



Доорх дүрсээс харахад 4 нарийвчилсан үзүүлэлтээс 2 нь дээшилсэн бол 1 үзүүлэлт нь буурч 0 хувь болсон байна.

Дүрс 25. Хэрэгжүүлэгч агентлагын ХАА-ны ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)



Агентлагууд өөрсдийн цахим хуудастаа тендерийн урилга, зарыг байршуулах байдал 2011 оны байдлаар 28,1 хувьтай байсан бол одоо 72,2 хувь өсчээ. Мөн тендерийн шалгаруулалтын талаарх мэдээллийг өмнө 18,8 хувьтай мэдээллэж байсан бол энэ удаад 33,3 хувь болж нэмэгдсэн байна.

5 ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 11 тохируулагч агентлагуудын болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 9. Тохируулагч агентлагуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)


№	Нэрс	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2011	2014	2011	2014
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	-	32	-	51
2	Зэвсэгт хүчний жанжин штаб	20,3	14,6	68	76
3	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар	-	23,1	-	66
4	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	31,4	53,7	33	7
5	Онцгой байдлын ерөнхий газар	27,5	29,4	45	59
6	Хил хамгаалах ерөнхий газар	33,2	34,6	25	41
7	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	17	37,6	78	35
8	Стандартчилал хэмжил зүйн газар	31,8	33,5	30	44
9	Тагнуулын ерөнхий газар	29,9	26,3	38	61
10	Төрийн өмчийн хороо	35,8	52,7	18	9
11	Цагдаагийн ерөнхий газар	34	41,3	22	25
12	Цөмийн энергийн газар	21,5	30,7	66	55
Тохируулагч агентлагийн дундаж		27,9	34,1		
Ерөнхий дундаж		28,7	36,9		

Тохируулагч агентлагуудын дундаж үзүүлэлт 2014 оны хувьд нийт төрийн байгууллагуудын дундаж үзүүлэлттэй ижил түвшинд байна. Харин 2011 оны судалгааны дундаж үзүүлэлтээс 6 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Нийт 12 байгууллагаас 8 агентлагийнх нь нийлбэр оноо өмнөх судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр өссөн байдалтай бол 2 агентлагийн нийлбэр оноо өмнөх үр дүнгээс төдийлөн өсөөгүй байна.

Өмнөх судалгааны үр дүнгээр хангалтгүй оноо авч сүүлийн байруудад жагсаж байсан байгууллагууд тодорхой хэмжээний ахиц гаргаж энэ удаагийн судалгаагаар дээгүүр жагсчээ. Жишээлбэл: Мэргэжлийн хяналтын газрын цахим хуудас 2011 онд 31,4 оноо авч 33 дугаар байрт жагсаж байсан бол энэ удаа 53,7 оноо авч 7 дугаар байранд оржээ. Мөн Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын цахим хуудас 2011 онд 17 хувиар 78 дугаар байранд байсан бол энэ удаад 37,6 оноо авч 35 дугаар байранд жагссан байна. Үүнээс харахад уг байгууллагууд иргэдэд мэдээллээ ил тод нээлттэй болгох тодорхой алхмуудыг авч түүнийх нь үр дүн гарч байгаа нь харагдаж байна. Гэвч хамгийн сайн үзүүлэлттэй агентлагууд 60-аас дээш оноо авч ил тод гэсэн ангилалд хараахан орж чадахгүй зарим талаар ил тод гэсэн ангилалд багтаж байна.

Мониторингийн үр дүнг таван үзүүлэлтийн дагуу хоёр оноор харьцуулан гаргаж өөрчлөлтийг дараах дүрсэд харууллаа.

Дүрс 26. Тохируулагч агентлагуудын ил тод байдал (хувь)




2014 онд 5 үзүүлэлтийн 3 нь болох мэдээллийн хамааралтай байдал, мэдээллийн найдвартай байдал, цаг үеийн байдал дээшилсэн бол бусад үзүүлэлтүүд ерөнхийдөө өмнөх судалгааны үр дүнтэй ижил түвшинд байна.

Хүснэгт 10. ТОП 5 үзүүлэлттэй тохируулагч агентлагууд (хувь)

Агентлагуудын нэрс	Нийлбэр оноо	
	2011	2014
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	31,4	53,7
Төрийн өмчийн хороо	35,8	52,7
Цагдаагийн ерөнхий газар	34	41,3
Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	17	37,6
Хил хамгаалах ерөнхий газар	33,2	34,6

Дүрс 27. Тохируулагч агентлагуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



Тохируулагч агентлагын цахим хуудасны хүртээмжтэй байдал 2014 онд 12,3 пунктээр бүүрч зарим талаар хүртээмжтэй гэсэн ангилалаас хүртээмжгүй гэсэн ангилал руу орсон бол хэрэглэхэд хялбар


байдал 11,6 пунктээр буурч хэрэглэхэд боломжтой гэсэн ангилалаас хэрэглэхэд төвөгтэй гэсэн ангилалд оржээ.

5.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Тохируулагч агентлагуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан агентлагуудын танилцуулга болох ерөнхий мэлээллээ цахим хуудастаа тавих байдал төдийлэн дээшлээгүй байна.

Дүрс 28. Тохируулагч агентлагуудын ерөнхий мэдээлэл (хувь)




Дээрх үр дүнгээс харахад байгууллагууд үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтоо цахим хуудастаа байршуулах байдал нь 54,5 хувьтай байснаас 91,7 хувь болж өссөн байна. Харин байгууллагын тэргүүлэх чиглэл өмнөх судалгааны үр дүнтэй ижил 0 хувьтай гарчээ.

5.1.1 Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл.

Байгууллагын олон нийттэй харьцах мэдээллийг дараах дүрсэд үзүүлсэн 7 үзүүлэлтээр хэмжсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад холбоо барих мэдээллүүд болох утасны дугаар, хаяг, иргэдийн хүлээн авч уулзах цагийн хуваарь зэрэг мэдээллүүд өмнөх судалгааны үр дүнгүүдтэй бараг ижил түвшинд байна.

Харин олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэрийг байршуулсан байдал 2011 онд 81,8 хувьтай байсан бол энэ удаад 33,3 хувь болтол буурсан байна. Мөн факсын дугаар байршуулсан байдал 81,8 хувиас 50 хувь болтол буурчээ.

Дүрс 29. Тохируулагч агентлагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)




Ерөнхийд нь дүгнэхэд тохируулагч агентлагуудын үйл ажиллагааны ил тод байдал 2011 онд 54,5 хувьтай байсан бол 2014 онд 48,9 хувь болж 5 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

5.2 Хүний нөөцийн ил тод байдал


Тохируулагч агентлагуудын цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт өмнөх судалгааны үр дүнгээс өссөн үзүүлэлттэй байна. 2011 оны байдлаар тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал 7,8 хувьтай байсан бол 2014 онд 27,5 хувьтай болсон нь бараг 3 дахин өссөн үзүүлэлт юм.

Дүрс 30. Тохируулагч агентлагуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)



Сул орон тооны талаарх мэдээллийг 2011 оны байдлаар нийт агентлагын 7,8 хувь нь ил тод байршуулж байсан бол энэ оны байдлаар 14,3 хувь болж өссөн байна. Мөн тухайн мэдээллийн цаг хугацааны хувьд тохиромжтой, эх сурвалж тодорхой зэрэг үзүүлэлт нь өмнөх үр дүнгээс тодорхой хувиар дээшилжээ.

Зураг 8. МХЕГ-ын хүний нөөцийн мэдээлэл




№	НЭГЭЭ	ОГНОО	LINK
1	Өмнөхөй аймгийн нэргэжлийн хяналтын газрын даргын албан тушаалд томилогдох ажиглагч сонгон шалгаруулалтыг заруулах байна.	2014-01-27	Үзэх...
2	Заман үед бодит дэвх зөлийн нэргэжлийн хяналтын албандаргын албан тушаалд томилогдох ажиглагч сонгон шалгаруулалтыг заруулах байна.	2014-03-11	Үзэх...
3	Хөвсгөл аймгийн нэргэжлийн хяналтын газрын даргын албан тушаалд томилогдох ажиглагч сонгон шалгаруулалтыг заруулах байна.	2014-03-11	Үзэх...
4	Булган дорноговь, ус, мод, хөтэй аймгийн болон нийслэлийн Нэргэжлийн хяналтын газрын даргын албан тушаалд томилогдох ажиглагч сонгон шалгаруулалтыг заруулах байна.	2014-07-08	Үзэх...
5	Нэргэжлийн хяналтын ерөнхий газрын тэргүүн даргын албан тушаалд томилогдох ажиглагч сонгон шалгаруулалтыг заруулах байна.	2014-07-08	Үзэх...

Жишээлбэл Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдал гэсэн тусдаа цэс байрлуулсан ба түүн дотроо нээлттэй ажлын байрны заруудыг олон нийтэд ил тавьсан байна. Эдгээр зар нь мэдээллийн найдвартай байдал болон цаг хугацааны хувьд тохирсон байдал зэргийг хангаж нийт 100 оноо аван хүний нөөцийн мэдээлэл бүрэн ил тод гэсэн үзүүлэлтийг хангасан байна.

5.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Тохируулагч агентлагуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг авч үзэхэд өмнөх судалгааны үр дүнгээс харьцангуй сайжирсан байна. Төсөв санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг дараах дүрсээс дэлгэрэнгүй харна уу.

Дүрс 31. Тохируулагч агентлагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Дээрх дүрсээс харахад төсөв санхүүгийн ил тод байдал 2011 оны судалгааны үр дүнгээр 2,6 хувь байсан бол 2014 оны судалгаагаар 30,2 хувь болж 27 пунктээр өсчээ. Тохируулагч агентлагууд төсөв


санхүүтэй холбоотой мэдээллээ цахим хуудастаа байршуулах байдал 1,5 хувь байснаас 13,8 хувь болж өссөн бол мэдээллийн эх сурвалж тодорхой байдал болон цаг хугацааны хувьд тохирсон байдал нь мөн адил өсч 8 хувьтай болжээ.

Хүснэгт 11. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 тохируулагч агентлаг (хувь)

Агентлаг	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
	МХЕГ	0	32,1	0	21,5	0	23,4	0
ТӨХ	5,4	26,8	3,6	17,9	1,3	18,2	10,2	62,8
СХЗГ	0	21,4	0	14,3	0	10,4	0	46,1

Агентлаг тус бүрээр үзүүлэлтийг харвал нийт 12 байгууллагаас Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 77 хувь, Төрийн өмчийн хороо 62,8 хувь, Стандартчилал хэмжилзүйн газар 46,1 хувьтай хамгийн өндөр оноо авч эхний гурван байранд оржээ. Эдгээрээс 2 агентлаг нь өмнөх судалгааны явцад 0 хувьтай байсан буюу төсөв санхүүгийн мэдээллээ цахим хуудастаа байршуулдаггүй, хаалттай байсан байна. Харин энэ удаад 40-өөс дээш оноо авч төсөв санхүүгийн мэдээлэл зарим талаар ил тод хэмээх ангилалд багтжээ.


Зураг 9. МХЕГ-ын цахим хуудас дахь төсөв, санхүүгийн мэдээлэл



Төсөв санхүүгийн ил тод байдлаар нэг дүгээр байранд орсон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын цахим хуудаснаас харахад тавьсан мэдээллүүд нь цаг хугацааны хувьд тохиромжтой буюу шинэлэг байж чадаж байна.

Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 8 үзүүлэлтээс 6 үзүүлэлт нь өмнөх судалгааны үр дүнгээс тодорхой хэмжээгээр өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа байгууллагын тухайн жилийн төсөв, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн биелэлт, санхүүгийн тайлан зэрэг үзүүлэлтүүд өмнөх судалгааны үр дүнгээс дор хаяж хоёр дахин нэмэгдсэн байна.

Дүрс 32. Тохируулагч агентлагуудын санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Харин хууль тогтоомжид заасан төлбөр хураамжийн хэмжээ өмнөх судалгаагаар 18,2 хувьтай байсан бол энэ онд 0 хувь болж буурчээ. Мөн дараа жилийн төсвийн төслийг одоо болтол судалгаанд хамрагдсан байгууллагууд ил тод болгох арга хэмжээ аваагүй байна.

5.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал


Тохируулагч агентлагуудын хувьд ХАА-ны тухай мэдээллээ цахим хуудастаа ил тод байршуулах байдал мөн өмнөх судалгааны үр дүнгээс ялимгүй нэмэгдсэн байдалтай байна. 2011 оны байдлаар 9,9 хувьтай байсан бол энэ удаагийн судалгаагаар 13,8 хувь болж даруй 2 дахин өссөн байна. Нарийвчилсан үзүүлэлтүүдээс харвал бүх үзүүлэлтүүд үл ялиг өсөлттэй байна. Тухайлбал ХАА-ны талаарх мэдээллийг байршуулсан байдал 5,8 хувиас 7,1 хувь болж, эх сурвалж тодорхой байдал 2 хувиас 3,6 хувь болж, цаг хугацааны хувьд тохиромжтой байдал 2,1 хувиас 3,1 хувь болж бага зэрэг өсчээ.

Дүрс 33. Тохируулагч агентлагуудын ХАА-ны ил тод байдал (хувь)



Нийт судалгаанд хамрагдсан агентлагаас нийт 2 агентлаг ижил 47,1 хувь болох хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна. Эдгээр нь Төрийн өмчийн хороо, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байв.

Зураг 10. Төрийн өмчийн хорооны ХАА-ны талаарх мэдээлэл



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ	Хайх: хэвцэг...	Онцлох мэдээ	
Гарчиг	Төрөл	Огноо	Асгал
Төрийн өмчлөлт болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдан авах ажиглалгааны 2014 оны төлөвлөгөө	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2014-08-28	Татах
Төрийн өмчийн хорооны 2013 оны II улирын, барил, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайлан	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2013-10-02	Татах
Үндэстний хороо төмөрцэн тусгай	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2013-06-17	Татах
Баруун ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах тусгай	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2013-05-27	Татах
Үндэстний хорооны дүгнэлт	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2013-05-23	Татах
Баруун ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах тусгай	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2013-05-21	Татах
Үндэстний хороо төмөрцэн тусгай	Худалдан авах ажиглалгааны ил тод байдал	2013-05-08	Татах

Доорх дүрсээс харахад 4 нарийвчилсан үзүүлэлтээс 2 нь бага зэрэг дээшилсэн бол 2 үзүүлэлт нь яг хэвэндээ 0 хувьтай гарсан байна.

Дүрс 34. Тохируулагч агентлагуудын ХАА-ны ил тод байдал (хувь)




Агентлагууд өөрсдийн цахим хуудастаа тендерийн урилга, зарыг байршуулах байдал 2011 оны байдлаар 36,4 хувьтай байсан бол одоо 41,7 хувь болж өсчээ. Мөн тендерийн шалгаруулалтын талаарх мэдээллийг өмнө 18,2 хувьтай мэдээлж байсан бол энэ удаад 25 хувь болж нэмэгдсэн байна.

6 АЙМГУУДЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт 21 аймгийн албан ёсны цахим хуудаст хийсэн мониторингийн нэгдсэн үр дүнг харуулна.

Зураг 11. Аймгуудын ил тод байдлын үзүүлэлт⁷



Аймгуудын цахим хуудсыг 5 үзүүлэлт тус бүрээр болон нийлбэр оноогоор 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулан харуулав.

Хүснэгт 12. Аймгуудын цахим хуудасны ерөнхий үзүүлэлт (хувь)

№	Нэрс	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2011	2014	2011	2014
1	Архангай	19.9	22.4	69	68
2	Баянхонгор	-	41.9	-	23
3	Баян-Өлгий	23.6	54.4	59	6
4	Булган	26.3	31.5	49	52
5	Говь-Алтай	22.2	70.8	63	1
6	Говьсүмбэр	37.4	26.1	14	62
7	Дархан-Уул	17.7	41.9	76	23
8	Дорноговь	21.6	55.6	65	4
9	Дорнод	-	53.5	-	8
10	Дундговь	15.6	41.6	80	24
11	Завхан	30.7	32.9	35	46
12	Орхон	-	56.5	-	3
13	Өвөрхангай	29.1	22.1	42	70
14	Өмнөговь	31.2	40.7	34	28
15	Сүхбаатар	28.6	22.2	44	69
16	Сэлэнгэ	26.4	39	48	32
17	Төв	28.6	32.4	44	49
18	Увс	32.8	41.1	26	26
19	Ховд	10.7	35.9	84	39
20	Хөвсгөл	29.2	54.7	41	5
21	Хэнтий	-	34.5	-	42
Аймгийн дундаж		25.1	40.9		
Ерөнхий дундаж		28.7	36.9		

Дундаж үзүүлэлтээрээ дийлэнх аймгийн үзүүлэлт өсчээ.


Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн үзүүлэлт 2011 оноос буурчээ. Ялангуяа Говьсүмбэр аймгийн цахим хуудас 2011 онд хамгийн өндөр оноотой байсан бол 2014 оны үр дүнгээр хамгийн

70-40 оноог улаанаар, 41-60 оноог шараар, 61-80 оноог ногооноор тэмдэглэв. 81-ээс дээш оноо цэнхэр байх хэдий ч одоогоор тийм шалгуур хангасан аймаг байхгүй байна.

муу үзүүлэлттэй цахим хуудасаар шалгарав. 2014 онд хамгийн өндөр үзүүлэлттэй нь Говь-Алтай аймгийн цахим хуудас, энэ сайт нь 70,8 хувийн үнэлгээтэй байгаа ба 2011 оны хамгийн өндөр үнэлгээтэй цахим хуудастай харьцуулахад 33,4 хувиар буюу 2 дахин өндөр байна.

Вэб мониторингийн үр дүнг таван үзүүлэлтээр нь задлаад хоёр оноор харьцуулан гарсан өөрчлөлтийг дараах графигт харууллаа.

Дүрс 35. Аймгуудын цахим хуудасны ил тод байдал (хувь)




2014 онд 5 үзүүлэлтийн 4 нь дээшилсэн, зөвхөн мэдээллийн хүртээмжтэй байдал бага зэрэг буурчээ.

Хүснэгт 13. ТОП 5 үзүүлэлттэй аймаг (хувь)

Аймгуудын нэрс	Нийлбэр хувь	
	2011	2014
Говь-Алтай	22.2	70.8
Орхон	-	56.5
Дорноговь	21.6	55.6
Хөвсгөл	29.2	54.7
Баян-Өлгий	23.6	54.4

Мэдээллийн хүртээмжтэй байдлыг 5 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд хэлний сонголт болон асуулт хариулт, хэлэлцүүлгийн булан аймгийн цахим хуудсуудад маш хангалтгүй байна. Харин бусад холбоотой байгууллагын линкийг байршуулсан нь арай дээр байгаа ч сүүлийн 3 жилд сайжирсангүй.

Дүрс 36. Аймгуудын цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)




Харин аймгуудын цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлыг үнэлэхэд сайтаас хэвлэх, илгээх, файл хадгалах зэрэг үзүүлэлтийн оноо буурчээ. Харин бусад үзүүлэлтийн оноо өссөн байна. Хэрэглэхэд хялбар байдлыг ерөнхийд нь дүгнэвэл харьцангуй сайн байгаа бөгөөд энэ нь 2011 онд 64 хувьтай байсан бол 2014 оны байдлаар 75 хувь болж өссөн нь бүхэлдээ аймгуудын цахим хуудсууд хэрэглэх байдлаараа боломжийн гэсэн ангилалд багтаж байна.

6.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг авч үзэхдээ байгууллагын талаарх 1. Байгууллагын ерөнхий мэдээлэл, 2. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл гэсэн хоёр хэсэгт ангилан авч үзсэн.

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Аймгуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан аймгууд эрхэм зорилго тавьсан байдал 2011 онд 29.4 хувьтай байсан бол 2014 онд 42.9 хувь болж 13.5 хувиар өсчээ.

Дүрс 37. Аймгуудын ерөнхий мэдээлэл (хувь)




Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг цахим хуудсанд мэдээлсэн байдал нь өмнөх судалгаанаас 26.3 хувиар нэмэгдсэн байна. Мөн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг мэдээлсэн

байдал 7.2 хувиар, албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийтлэх нь 17.1 хувиар өсчээ. Дээрх дүрсээс харахад байгууллагын үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг харуулах дөрвөн үзүүлэлтээс үйл ажиллагаа стратегийн зорилго зорилт болон тэргүүлэх чиглэл нь төдийлөн ил тод биш, тодорхойгүй гэсэн үнэлэлт өгч болох ба эрхэм зорилго, мөн албан хаагчийн ёс зүйн дүрэм нь зарим талаар хангалттай тавигдсан байна.

Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл. Олон нийттэй харьцах мэдээллийг дараах 7 үзүүлэлтээр хэмжсэн. Өмнөх судалгаатай харьцуулахад тухайн аймгийн ЗДТГ-ын цахим шуудангийн хаяг, байгууллагын хаяг, байгууллагатай холбоо барих утас зэрэг нарийвчилсан мэдээлэл бага зэрэг буурсан байхад олон нийттэй харилцах мэргэжилтний овог нэр гэсэн үзүүлэлт нилээд буурчээ.

Дүрс 38. Аймгуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)



Харин иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, тухайн цахим хуудаснаас шууд холбогдох боломжтой аймгийн цахим хуудас 2011 онд байхгүй байсан бол 2014 онд энэ мэдээлэл зарим аймгийн цахим хуудаст байршдаг болжээ. Гэсэн хэдий ч эдгээр үзүүлэлт хангалтгүй хэвээр байна. Мөн байгууллагын хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллүүд буурсан, зарим талаар ил тод гэсэн үнэлгээ авч байгаа нь цаашид эдгээр мэдээллийг илүү ил тод байршуулах шаардлагатайг харуулна.


Ялангуяа Архангай, Сүхбаатар аймгууд 13,3 хувьтай, Дархан-Уул, Ховд аймгууд 20 хувьтай байгаа нь байгууллагын үйл ажиллагаа хамгийн хаалттай гэсэн ангилалд багтаж байхад Дорнод 60 хувьтай, Орхон, Өмнөговь аймгууд 66,7 хувьтай хамгийн өндөр оноо авч байгууллагын үйл ажиллагаа ил тод гэсэн ангилалд оржээ.

Ерөнхийд нь дүгнэхэд аймгуудын цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал 2011 онд 37,6 хувьтай байсан бол 2014 онд 36,8 хувь болж бага зэрэг буурчээ. Энэ үзүүлэлт нь аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаа хаалттай гэсэн үнэлгээтэй хэвээр байгааг харууллаа.

6.2 Хүний нөөцийн ил тод байдал

Аймгуудын цахим хуудасны хүний нөөцийн мэдээлэлд гол төлөв төрийн жинхэнэ албаны мэргэшлийн болон нөөцийн судалгаа тавигдсан байсан. Тиймээс энэ үзүүлэлтийг тус судалгаа болон сул орон тоог нөхөх зар тавигдсан эсэх байдлаар үнэлсэн.

Дүрс 39. Аймгуудын хүний нөөцийн ил тод байдал (хувь)



Хүснэгт 14. Хүний нөөцийн ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)

Аймгийн нэрс	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
Баян-Өлгий	43	43	0	29	0	0	43	71.4
Дархан-Уул	43	43	29	29	29	29	100	100
Төв	0	43	0	29	0	29	0	100

Хүний нөөцийн ил тод байдал буюу сул орон тооны мэдээллийг аймаг тус бүрээр нь үнэлэхэд бүрэн шалгуур хангасан 2 аймаг байна. Шалгуурыг бүрэн хангасан 2 аймгийн хүний нөөцийн ил тод байдал нь бүрэн хангагдсан ба тухайн мэдээлэл нь бүрэн цогц, эх сурвалж тодорхой, нийтэлсэн хугацаа тодорхой, тогтмол шинэчлэгдэж байдаг зэрэг үзүүлэлтүүдийг хангасан юм. Ялангуяа Дархан-Уул аймгийн хувьд сул орон тооны мэдээллийг цаг тухай бүрт нь тогтмол шинэчилдэгийг 2011 оны болон 2014 оны судалгааны үр дүн харуулж байна. Мөн үүний дараа Баян-Өлгий аймгийн цахим хуудас сул орон тооны талаарх мэдээллээ тогтмол шинэчилдэг байна.

Зураг 12. Баян-Өлгий аймгийн цахим хуудас дахь хүний нөөцийн мэдээлэл

Гарчиг	Огноо	Файл
Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн болон нөөцийн судалгаа	2014.06.06	Татаж авах
Гишүүдийн ажил үүргийн хуваарь	2014.05.28	Татаж авах
ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙГУУЛЛАГАД мэдээллийн технологийн чиглэлээр төрийн үйлчилгээний албан тушаалын сул орон тоог нөхөх	2014.05.15	Файл байхгүй
Баян-Өлгий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл	2014.03.28	Файл байхгүй
Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалтны ажлын байрны сул орон тоог нөхөх иргэдийг сонгон шалгаруулах шалгалтын тухай зар	2014.03.25	Файл байхгүй

Сүхбаатар, Сэлэнгэ аймгуудын хүний нөөцийн ил тод байдал 2011 онд 100 хувьтай байсан бол 2014 оны судалгааны үр дүнгээр 0 хувь болж буурчээ.


Ерөнхийд нь дүгнэхэд 71,4 хувьтай үнэлэгдсэн аймгуудын хүний нөөцийн ил тод байдал хангалттай ил тод, 42,8 хувьтай байгаа аймгуудын хүний нөөцийн ил тод байдал зарим талаар ил тод байна. Харин хүний нөөцийн ил тод байдал хангалтгүй буюу огт байхгүй 12 аймаг байна.

Энэ байдал 2011 онд 36,1 хувьтай байсан бол 2014 онд 29,2 хувь болон буурчээ.

6.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Аймгуудын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлыг дараах дүрсэд харуулья.

Дүрс 40. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Хүснэгт 15. Төсөв санхүүгийн ил тод байдлын үнэлгээ ТӨП 3 аймаг (хувь)

Аймгийн нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
Говь-Алтай	0	43	0	29	0	29	0	100
Орхон	-	32	0	4	0	22	0	57.8
Хөвсгөл	5	29	4	22	3	23	11.5	71.6

Аймаг тус бүрээр нь харвал 2011 онд аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдал маш хангалтгүй хаалттай байсан ба Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Хөвсгөл гэсэн 4 аймаг л төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг бага хэмжээгээр нийтэлж бусад 15 аймгийн цахим хуудаст төсөв, санхүүтэй холбоотой ямар ч мэдээлэл байгаагүй. Харин энэ байдал 2014 онд сайжирч Говь-Алтай аймгийн төсөв, санхүүгийн ил тод байдал бүрэн нээлттэй, Хөвсгөл аймгийн төсөв, санхүүгийн мэдээлэл хангалттай ил тод байна. Хаалттай огт мэдээлэлгүй аймаг энэ онд 3 байгаа нь Архангай, Булган, Говьсүмбэр аймгууд байна.

Дүрс 41. Хөвсгөл аймгийн цахим хуудас дахь төсөв, санхүүгийн мэдээлэл



Төсвийн ил тод байдлыг үнэлсэн дараах 8 үзүүлэлтээс байгууллагын тухайн жилийн төсөв, өнгөрсөн оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт зэргийн оноо нь хангалттай ил тод гэсэн ангилалд оржээ.

Дүрс 42. Аймгуудын төсөв санхүүгийн ил тод байдлын үзүүлэлтүүд (хувь)




Харин хууль тогтоомжид заагдсан төлбөрийн хэмжээг нийтлэх байдал хангалтгүй байна. ЗДТГ нь иргэдэд үйлчлэх гэдгээс илүү төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг байгууллагуудаа удирдлага, оновчтой бодлого зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй хэдий ч хууль, дүрэм, журмаар батлагдсан төлбөр, хураамжтай холбоотой мэдээллийг иргэдэд түгээх нь чухал юм.

Аймгууд төсөв санхүүгийн мэдээлээ цахим хуудастаа байршуулдаг байдал 2011 онд ердөө 2,5 хувьтай байсан бол 2014 онд 38,2 хувь болж өсчээ. Энэ нь төсөв санхүүгийн мэдээлэл хаалттай гэсэн ангиллаас зарим талаар ил тод гэсэн ангилалд орж дэвшил хийжээ.

6.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Аймгуудын ХАА-ны тухай мэдээлэл тухайн аймгийнхаа албан ёсны цахим хуудаст цаг тухай бүрт нь байршиж байх нь ихээхэн чухал. Өмнө нь өгүүлсэнчлэн хэдийгээр төрийн байгууллагын ХАА-ны талаарх мэдээллийг түгээдэг тусдаа цахим хуудас байгаа хэдий ч бид өмнөх арга зүйгээ баримтлан тухайн байгууллагын цахим хуудсанд мэдээлэх ёстой гэж үзсэн.

Дүрс 43. Аймгуудын цахим хуудасны ХАА-ны ил тод байдал (хувь)




ХАА-г дүрсэд харуулсан гурван үзүүлэлтээр оноо өгөхөд Дархан-Уул, Говь-Алтай, Баянхонгор аймгийн цахим хуудас дахь ХАА-ны талаарх мэдээлэл ил тод байна. Харин Архангай, Орхон зэрэг 7 аймгийн ХАА-ны талаарх мэдээлэл хаалттай, ялангуяа Өмнөговь, Сүхбаатар аймгийн цахим хуудас дахь ХАА-ны ил тод байдал 2011 онд зарим талаар нээлттэй байсан бол энэ онд мууджээ.

Хүснэгт 16. ХАА-ны ил тод байдал ТОП 3 аймаг (хувь)

Аймгийн нэрс	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
Баянхонгор	-	32	-	22	-	11	-	65
Говь-Алтай	0	32	0	14	7	0	0	66.4
Дархан-Уул	0	11	0	7	0	20	0	73.6

Зураг 13. Баянхонгор аймгийн цахим хуудас дахь ХАА-ны талаарх мэдээлэл



ХАА-ны ил тод байдлыг үнэлэх дараах 4 үзүүлэлтээс тендерийн урилга, зарыг аймгийн цахим хуудсууд байршуулах байдал нэмэгджээ. Харин үлдсэн 23,8 хувь нь тендерийн урилга, зарыг байршуулаагүй эсвэл ямар нэгэн тендер зарлагдаагүй байна.

Дүрс 44. Аймгуудын ХАА-ны ил тод байдал (хувь)



Тендер шалгаруулалтын үр дүнг нийтлэх байдал хангалттай нээлттэй хэмжээнд, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан зарим талаар ил тод нээлттэй хэмжээнд байна. Харин ХАА-нд хийсэн хяналт, шалгалт, аудитын дүн байхгүй байгаа нь ХАА-нд төдийлөн хяналт, шалгалт хийдэггүй, хийсэн ч үр дүнг олон нийтэд мэдээлдэггүй, хаалттай байдаг гэж дүгнэж болно.

Аймгуудын ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээ 2011 онд хаалттай байсан бол 2014 онд 22,4 хувиар өсч зарим талаар ил тод нээлттэй болжээ.

7 УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГАА, ДҮҮРГҮҮДИЙН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ удаагийн мониторингид Улаанбаатар хотын захиргаа болон дүүргүүдийн цахим хуудсуудыг шинээр хамруулсан.

Зураг 14. Дүүргүүдийн ил тод байдлын үзүүлэлт⁸



Дүүргүүдийн ил тод байдал нь аймгийнхтай харьцуулбал муу байна. Дөнгөж Баянгол дүүргийн мэдээлэл зарим талаар ил тод гэсэн ангилалд орж байна.

Доорх хүснэгт дэх 11 байгууллагаас өмнөх судалгаанд хамрагдсан нь зөвхөн НЗДТГ-ын цахим хуудас нь 2011 онтой харьцуулагдана. Тиймээс энэ байгууллагын цахим хуудсыг өмнөх үр дүнтэй нь тусад нь харьцуулан харууллаа.


Хүснэгт 17. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны ил тод байдал (хувь)

№	Дүүргүүдийн нэрс	Нийлбэр оноо	Эрэмбэ /Ранк/
1	НЗДТГ	40.9	27
2	УБ хотын захирагчийн ажлын алба	22.6	67
3	БГД-ийн ЗДТГ	43.4	21
4	БХД-ийн ЗДТГ	22.1	70
5	БЗД-ийн ЗДТГ	30.5	56
6	БНД-ийн ЗДТГ	25.4	64
7	ЧД-ийн ЗДТГ	39.6	30
8	СБД-ийн ЗДТГ	34	43
9	СХД-ийн ЗДТГ	39.2	31
10	ХУД-ийн ЗДТГ	20.1	72
11	НД-ийн ЗДТГ	31.1	53
Нийслэлийн дундаж		31.7	
Ерөнхий дундаж		36.9	

Баянгол дүүрэг болон НЗДТГ-ын цахим хуудсууд бусдаасаа хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа хэдий ч дөнгөж зарим талаар ил тод гэсэн ангилалд байна. Бусад цахим хуудсууд 40-өөс доош хувийн үзүүлэлттэйгээр ил тод биш гэсэн ангилалд багтаж байна.

80-40 оноо улаанаар, 41-60 оноог шараар тэмдэглэж байгаа. Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн үнэлгээ 39 хувьтай байгаа тул зарим талаар нээлттэй гэсэн ангилал руу ойртож байгаа гэх утгаар улбар шараар тэмдэглэв.

Дүрс 45. НЗДТГ-ын цахим хуудасны үнэлгээнд гарсан өөрчлөлт(хувь)




НЗДТГ-ын цахим хуудас бусдаасаа харьцангуй өндөр үзүүлэлтийг энэ удаагийн судалгаа харуулж байна. Энэ нь 2011 оныхоос 27,6 хувиар өсчээ. Ялангуяа цаг үеийн байдал буюу мэдээлэл нийтэлсэн хугацаа зэрэг нь илүү тодорхой болж сайжирчээ.

Хүснэгт 18. Нийслэлийн захиргаа, дүүргийн ТОП 5 байгууллага

Дүүргүүдийн нэрс	Нийлбэр хувь	Зэрэглэл /Ранк/
НЗДТГ	40.9	27
БГД-ийн ЗДТГ	43.4	21
ЧД-ийн ЗДТГ	39.6	30
СХД-ийн ЗДТГ	39.2	31

Нийслэлийн захиргаа, дүүргийн нийт 11 байгууллагаас 2 нь л мэдээллээ зарим талаар ил тод нээлттэй байршуулдаг. Бусад 9 байгууллагын хувьд мэдээлэл хаалттай гэсэн ангилалд багтаж байна.

Дүрс 46. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудсыг хэрэглэх байдал (хувь)



7.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Мониторингийн үр дүнгээс харахад нийслэлийн захиргаа болон дүүргүүд цахим хуудастаа эрхэм зорилгоос илүүтэйгээр үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтоо нийтэлжээ.

Дүрс 47. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ерөнхий үзүүлэлт (хувь)



Дээрх дүрсээс харахад байгууллагын үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг харуулах дөрвөн үзүүлэлтээс тэргүүлэх чиглэл нь төдийлөн ил тод биш, тодорхойгүй гэсэн үнэлэлт өгч болох ба эрхэм зорилго, мөн албан хаагчийн ёс зүйн дүрэм нь зарим талаар хангалттай тавигдсан гэсэн ангилалд багтаж, үйл ажиллагаа стратегийн зорилго зорилт нь хангалттай ил тод байна гэж дүгнэж болохоор байна. Байгууллагын олон нийттэй харьцах мэдээлэл. Олон нийттэй харьцах мэдээлэлд байгууллагын хаяг, байгууллагатай холбоо барих утас зэргийг багтаасан бол цахим шуудангийн хаяг, төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт зэрэг үйлчилгээ авахтай холбогдсон мэдээллүүд мөн хангалттай хэмжээнд тавигджээ.

Дүрс 48. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн олон нийттэй харилцахтай холбоотой мэдээлэл (хувь)




Дүгнэхэд нийслэлийн захиргаа, дүүргүүдийн цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал 31,7 хувьтай байгаа нь төдийлөн ил тод биш байна.

7.2 Хүний нөөцийн ил тод байдал

Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдлын ерөнхий үнэлгээг харуулья.

Дүрс 49. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал (хувь)



Хүснэгт 19. Хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ ТОП 3 дүүрэг (хувь)


Дүүргүүдийн нэрс	Мэдээлэл байгаа эсэх	Эх сурвалж тодорхой эсэх	Цаг хугацаа нь байгаа эсэх	Нийт хувь
БХД-ийн ЗДТГ	42.8	0	28.6	71.4
СХД-ийн ЗДТГ	42.8	28.6	28.6	100
НД-ийн ЗДТГ	42.8	28.6	28.6	100

Нийт 11 байгууллагаас дүрсэд харуулсан 3 байгууллага ил тод байдлын шалгуурыг хангасан байна. Үүнээс СХД, Налайх дүүргийн хүний нөөцийн ил тод байдал бүрэн нээлттэй байгаа бол БХД-ийн хүний нөөцийн мэдээлэл хангалттай нээлттэй гэсэн үнэлгээг авчээ. Харин үлдсэн байгууллагын хувьд хүний нөөцийн сул орон тооны тухай мэдээллийг огт тавьдаггүй хаалттай байна. Тиймээс нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдлын дундаж үзүүлэлт муу байна. НЗДТГ-ын үзүүлэлт 2011 онд ч мөн адил 0 хувийн үнэлгээ авч маш муу байгааг харуулжээ.

Зураг 15. БХД-ийн хүний нөөцийн ил тод байдал

7.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Дүрс 50. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)



Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хүний нөөцийн ил тод байдал 21,7 хувьтай байгаа нь энэ талын мэдээлэл хаалттай байгааг харуулна.


Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн төсөв санхүүгийн мэдээлэл 3 байгууллагаас бусад байгууллага нь бага хэдий ч тодорхой хэмжээгээр тавигджээ.

Хүснэгт 20. Төсөв санхүүгийн ил тод байдал ТОП 3 нийслэл, дүүрэг(хувь)

Дүүргүүдийн нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх	Эх сурвалж тодорхой эсэх	Цаг хугацаа нь байгаа эсэх	Нийт хувь
НЗДТГ	32.1	0	23.4	55.5
БГД-ийн ЗДТГ	26.8	0	14.3	41.1
ЧД-ийн ЗДТГ	21.4	0	15.6	37
Нийт дундаж	12.6	0.7	8.4	21.7

НЗДТГ-ын төсөв санхүүгийн мэдээлэл хамгийн өндөр оноотой байгаа ба мөн Баянгол дүүргийн ЗДТГ-ын төсөв, санхүү нь зарим талаар нээлттэй гэсэн ангилалд орж байна. Харин Багануур болон Хан-Уул дүүргийн ЗДТГ-аас бусад дүүргийн төсөв, санхүүгийн мэдээлэл бага хэмжээнд тавигдсан байгаа хэдий ч хангалтгүй, харин энэ 2 дүүргийн санхүүтэй холбоотой мэдээлэл огт байхгүй байна. Энэ байдал мөн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны хувьд ч ижил түвшинд байгааг анхаарах хэрэгтэй.


Зураг 16. БГД-ийн төсөв, санхүүгийн ил тод байдал



Нийслэл болон дүүргүүдийн ЗДТГ-ын хувьд дунджаар 21,7 гэсэн үнэлгээг харуулж байгаа нь ерөнхийдөө төсөв, санхүүгийн мэдээлэл хангалтгүй, хаалттай гэж үнэлэгдэнэ.

7.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Дүрс 51. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал (хувь)



ХАА-ны дундаж үзүүлэлт нийслэлийн захиргаа, дүүргүүдийн хувьд 19,3 хувь байгаа нь энэ талын мэдээлэл хаалттай байгааг харуулна.


Нийт 11 байгууллагын 4-өөс бусад байгууллага нь тодорхой хэмжээгээр мэдээлэл тавигдсан байна.

Хүснэгт 21. Нийслэлийн захиргаа, дүүргүүдийн ХАА-ны ил тод байдал ТОП 2 (хувь)

Дүүргүүдийн нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх	Эх сурвалж тодорхой эсэх	Цаг хугацаа нь байгаа эсэх	Нийт хувь
ЧД-ийн ЗДТГ	21.4	14.3	11.4	47.1
НД-ийн ЗДТГ	21.4	14.3	11.4	47.1
Нийт дундаж	8.8	5.9	4.7	19.3

Чингэлтэй, Налайх дүүргийн хувьд ХАА-ны ил тод байдал зарим талаар нээлттэй түвшинд байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Ихэнх байгууллагын ХАА-ны ил тод байдлын үнэлгээ 23,6 хувьтай байгаа нь хангалтгүй оноо юм.

Зураг 17. ЧД-ийн ХАА-ны ил тод байдал




ХАА нь ерөнхий дунджаар 19,3 хувьтай байгаа нь мэдээлэл хаалттай байгааг харуулна. Эдгээрээс дүгнэвэл нийслэл болоод дүүргүүдийн цахим хуудсуудад ганц хоёр тендерийн урилга зэрэг мэдээллүүдийг оруулдаг ч тэдгээрийн шалгаруулалт, үр дүн зэргийг мэдээлэх байдал маш муу байгааг онцлох хэрэгтэй.

8 ПАРЛАМЕНТИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ВЕБСАЙТЫН ҮЗҮҮЛЭЛТ

Парламентийн харьяа байгууллагуудын ил тод байдлын ерөнхий үнэлгээ 32-48 хувийн хооронд ойролцоо үр дүнг харуулж байна.

Дүрс 52. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдал (%)



Тус байгууллагуудын цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг арга зүйн дагуу ангилахад дийлэнх байгууллага нь мэдээлэл нь хаалттай гэж үнэлэгджээ.

Хүснэгт 22. Парламентын харьяа байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ (хувь)


№	Байгууллагын нэрс	Нийлбэр оноо		Эрэмбэ /Ранк/	
		2011	2014	2011	2014
1	ТАЗ	40.9	36.5	7	38
2	АТГ	31.5	32.9	32	46
3	СЗХ	30.7	35.2	35	40
4	СЕХ	19	46.1	72	16
5	ХЭҮК	27.1	48	46	13
6	ҮАГ	35.1	40	20	29
7	ҮСХ	40.6	45.3	10	18
8	Монгол банк	35.1	37.6	19	35
9	УИХ	23.8	32.6	58	48
Парламентын харьяа байгууллагын дундаж		28.8	39.3		
Ерөнхий дундаж		28.7	36.9		

Дээрх байгууллагуудаас Хүний эрхийн үндэсний комисс, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагууд бусдаасаа өндөр оноотой, мэдээллийн ил тод байдал зарим талаар нээлттэй байна. Бусад байгууллагуудын хувьд тодорхой мэдээллүүд байгаа ч энэ нь хангалттай ил тод биш байна. Үүнийг 2011 оны үр дүнтэй харьцуулан харвал өссөн үр дүнг харуулж байгаа хэдий ч өсөлт нь тун бага хэмжээтэй байгааг дүрсээс харж болно.

Ил тод байдлыг илтгэх 5 үзүүлэлтүүдээр нь харьцуулан авч үзвэл мэдээллийн хамааралтай байдал, цаг үеийн байдал, вебсайтын хэрэглэхэд хялбар байдал нэмэгдсэн ч мэдээллийн найдвартай байдал, мэдээллийн хүртээмжтэй байдал зэрэг үзүүлэлтүүд буурсан байна. Энэ нь олон нийтэд холбогдолтой мэдээллийг цаг тухайд нь хүргэх, цахим хуудсыг ашиглах байдлыг нэмэгдүүлсэн ч тухайн мэдээллийн


эх сурвалж тодорхойгүй, иргэдэд тодорхой асуудлын хүрээнд онлайн хэлбэрээр асуултанд хариулт авах, хэлэлцүүлэг хийх, мэдээлэл авах боломж хомс байгааг харуулж байгаа юм.

Дүрс 53. Парламентын харьяа байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ(хувь)



Мэдээллийн найдвартай байдал 1,2 хувиар, хүртээмжтэй байдал 1,1 хувиар буурсан хэдий ч бусад 3 үзүүлэлт нь дунджаар 4 хувиар өссөн нь нийт үзүүлэлт 2011 оноос өссөн үзүүлэлттэй гарахад нөлөөлжээ. Парламентын байгууллагын ил тод байдлын үнэлгээ 2011 оноос 10,5 хувиар өссөн хэдий ч хараахан нээлттэй гэсэн ангилал руу шилжээгүй байна.

Дүрс 54. Парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны хэрэглэх байдал (хувь)



Мэдээллийн хүртээмжтэй байдлыг 5 үзүүлэлтээр үнэлэхэд холбоотой байгууллагын линк болон хэлний сонголт, тогтмол асуудаг асуултуудын хариулт зэрэг нь өсчээ. Харин асуулт хариултын булан болон хэлэлцүүлгийн буланг ажиллуулах явдал маш сул байна. Эдгээр 5 үзүүлэлтийг дундажлан үзвэл 2011 онд 56,4 хувьтай байсан бол 2014 онд 51,1 хувь болон буурсан үзүүлэлт харагдана.


Хэрэглэхэд хялбар байдал 21,7 хувиар нэмэгджээ. Үүнийг үзүүлэлт тус бүрээр нь шинжлэн үзвэл сайтын меню ойлгомжтой байдал, өнгөний зохицол, хайлтын цэс, сайт маф зэрэг үзүүлэлтүүд 100

хувийн үзүүлэлттэй бол сайтаас хэвлэх, хадгалах, илгээх боломжууд хамгийн бага түвшинд байна. Хэрэглэхэд хялбар байдлыг ерөнхийд нь дүгнэж үзвэл харьцангуй сайн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2011 онд хэрэглэхэд төвөгтэй гэсэн үр дүнг үзүүлж байсан бол 2014 оны байдлаар хэрэглэхэд маш хялбар гэсэн ангилалд багтаж байна.

8.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын ерөнхий мэдээлэл. Аймгуудын цахим хуудсанд хийсэн мониторингийн үр дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан аймгуудын эрхэм зорилгоо тавьсан байдал 2011 онд 29.4 хувьтай байсан бол 2014 онд 42.9 хувь болж 13.5 хувиар өсчээ.


Дүрс 55. Парламентын харьяа байгууллагуудын ерөнхий мэдээллийн үнэлгээ (хувь)



Үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг цахим хуудсанд мэдээлсэн байдал нь өмнөх судалгаатай харьцуулахад 26.3 хувиар нэмэгджээ. Мөн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг мэдээлсэн байдал 7.2 хувиар, албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийтлэх нь 17.1 хувиар өсчээ. Дээрх дүрсээс харахад байгууллагын үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг харуулах дөрвөн үзүүлэлтээс үйл ажиллагаа стратегийн зорилго, зорилт болон тэргүүлэх чиглэл нь төдийлөн ил тод биш, тодорхойгүй гэсэн үнэлэлт өгч болох ба эрхэм зорилго, мөн албан хаагчийн ёс зүйн дүрэм нь зарим талаар хангалттай тавигдсан гэсэн ангилалд багтаж байна.

Байгууллагын олон нийттэй харилцах мэдээлэл. Олон нийттэй харилцах мэдээллийн дүнг өмнөх судалгаатай харьцуулахад тухайн байгууллагын хаяг, байгууллагатай холбоо барих утас, факс, и-мэйл зэрэг мэдээллээ байршуулах нь нэмэгджээ. Харин иргэдтэй харилцах ажилтны нэр, цагийн хуваарь, цахим орчинд шууд холбогдох боломж зэрэг үзүүлэлт буурчээ.

Дүрс 56. Парламентын харьяа байгууллагуудын олон нийттэй харилцах мэдээлэл (хувь)



Дүгнэхэд парламентын харьяа байгууллагуудын цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал 2011 онд 47,3 хувьтай байсан бол 2014 онд 46,7 хувь болж үл ялих бүүрчээ. Тиймээс үйл ажиллагааны ил тод байдал зарим талаар ил тод гэсэн үнэлгээг хэвээрээ авч байна.

8.2 Хүний нөөцийн ил тод байдал

Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээг байгууллага тус бүрээр дор харуулав.

Дээрх 9 байгууллагаас 2011 онд 2 байгууллага хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлт хангасан байсан бол 2014 онд мөн тооны байгууллага хүний нөөцийн ил тод байдлын үзүүлэлтийг хангасан байна. Гэхдээ чанарын хувьд 2014 онд бүүрсэн үзүүлэлт харагдаж байна.

Дүрс 57. Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдал(хувь)




Парламентын харьяа байгууллагуудын хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээ 2011 оноос 1,6 хувиар буурчээ.

Хүснэгт 23. ПХБ-ын хүний нөөцийн ил тод байдал ТОП 2 (хувь)

Нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цагхугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
ХЭҮК	0	43	0	0	0	29	0	71.4
ҮАГ	43	43	29	0	29	0	100	42.8

Хүний нөөцийн ил тод байдал ямар нэгэн хэмжээнд ил тод байгаа 2 байгууллага нь Хүний эрхийн үндэсний комисс ба Үндэсний аудитын газар зэрэг байна.

Зураг 18. ХЭҮК-ын хүний нөөцийн ил тод байдал




Хүний эрхийн үндэсний комиссын сул орон тооны зар мэдээллийн ил тод байдал цэсэнд шууд татаж авахаар байршсан байна.

8.3 Төсөв санхүүгийн ил тод байдал

Төсөв, санхүүгийн ил тод байдлын дундаж үзүүлэлтийг харуулав.

Дүрс 58. Парламентын харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн ил тод байдал (хувь)




Нэрс	Мэдээ-лэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цагхугацаа нь байгаа эсэх		Нийт хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
ХЭҮК	0	32	0	0	0	22	0	54.2
ҮАГ	11	27	7	0	8	18	25.7	45
ҮСХ	0	27	0	0	0	20	0	46.3

Хүснэгт 24. Төсөв, санхүүгийн ил тод байдал ТОП 3 (хувь)

Парламентын харьяа байгууллагуудаас Хүний эрхийн үндэсний комисс, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллага хамгийн өндөр үнэлгээг авсан байгаа ч хүний нөөцийн ил тод байдал зарим талаар нээлттэй гэсэн ангилалд хамаарч байна. Хамгийн бага үнэлгээг Монгол банк авсан ба сул орон тоотой холбоотой мэдээлэл огт байхгүй. Бусад байгууллагын хувьд бага хэмжээний мэдээлэл байгаа ч энэ нь хангалттай ил тод биш байна.

Зураг 19. ҮАГ-ын төсөв, санхүүгийн ил тод байдал




Үндэсний аудитын газар нь төрийн гол байгууллагуудын санхүүгийн аудитын тайланг татаж болохоор тавьсан ба өөрсдийн зарим тайланг мөн байршуулжээ.

Ерөнхийдөө төсөв, санхүүгийн ил тод байдлын үнэлгээ 2011 оноос хойш 24 хувиар өссөн байна. 2011 онд хүний нөөцийн талаарх мэдээлэл маш хаалттай байсан бол 2014 онд хангалттай биш ч бага хэмжээгээр тавигддаг болжээ.

8.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал

ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээг дор харууллаа.

Дүрс 59. ХАА-ны ил тод байдал (хувь)



Парламентын харьяа байгууллагын ХАА-ны ил тод байдлын дундаж үнэлгээ 2011 онд 8,3 хувьтай байсан бол 2014 онд 10,1 хувиар өсч 19,4 хувьтай болжээ. Гэвч энэ байдал нь ил тод байдлын шалгуурыг хангахгүй байгаа юм.

Хүснэгт 25. ПХБ-уудын ХАА-ны ил тод байдлын үнэлгээ ТОП 3 (хувь)

Нэрс	Мэдээлэл байгаа эсэх		Эх сурвалж тодорхой эсэх		Цаг хугацаа нь байгаа эсэх		Нийлбэр хувь	
	2011	2014	2011	2014	2011	2014	2011	2014
СЕХ	0	32	0	0	0	20	0	52.1
ХЭҮК	0	32	0	0	0	17	0	49.3
Монгол банк	11	21	7	0	6	9	23.6	30

Нийт 9 байгууллагаас 3 байгууллагын худалдан авах ажиллагааны мэдээлэл хаалттай хэвээр байна. СЕХ болон ХЭҮК-ын ХАА-ны талаарх мэдээлэл зарим талаар нээлттэй байна.

Зураг 20. СЕХ-ны ХАА-ны ил тод байдал



СЕХ-ны ил тод байдал бусад байгууллагаас хамгийн сайн мэдээлэлтэй байна.

9 Хавсралт

9.1 Үндсэн ойлголтууд

Төрийн байгууллын “ил тод” болон “нээлттэй байдал” гэдэг нь ялгаатай ойлголтууд бөгөөд уг мониторинг эхний ойлголтод суурилна. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын тодорхойлсноор ил тод байдал бол сайн засаглалын түлгын гурван чүлүү болох хариуцан тайлагнах байдал (accountability); ил тод байдал (transparency), нээлттэй байдал (openness)-ын нэг бүрэлдэхүүн хэсэг юм (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази, Номхон Далайн Эдийн засаг Нийгмийн Комисс ил тод байдлыг сайн засаглалыг илэрхийлэх найман шинж байдлын нэг гэж үзээд энэ нь нээлттэй байдал гэх ойлголтос тусдаа болохыг тэмдэглэжээ. Мөн бидний судалгаандаа гол мөрдлөг болгон ашиглаж буй 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” нь нээлттэй байдлыг гэхээс илүүтэй ил тод байдлыг онцлон авч үзсэн байна. Тиймээс эдгээрээс үндэслэн мониторинг нь “ил тод” байдлыг онцлон шинжилсэн.

Ил тод байдал: “Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь найдвартай, холбогдолтой, цаг үеэс хоцролгүй олон нийтэд хүрч байгааг хэлнэ” (OECD, 2011). Харин НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн Засаг Нийгмийн комисс “Ил тод байдал гэдэг нь төрөөс гаргаж буй шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээлэл нь уг шийдвэрийн нөлөөлж буй хэнд ч чөлөөтэй, хүртээмжтэй байхыг хэлнэ” гэжээ (UNESCAP, 2011).

Цахим үйлчилгээ: Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлдэг үндсэн үйлчилгээг цахим хуудсаар дамжуулан үзүүлэх

Цахим оролцоо: Төрийн байгууллагын үйл ажиллагаа болон гаргаж буй хууль, тогтоол, шийдвэрт нь иргэд цахим хуудас ашиглан оролцох, санал хүсэлтээ илгээх боломж

Төрийн байгууллагын цахим хуудас: Төрийн байгууллагаас өөрсдийн шийдвэр, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн болон иргэдэд шаардлагатай, хуулиар хориогүй бусад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, төрийн үйлчилгээг сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэхэд зориулсан вэб технологид суурилсан мэдээллийн систем

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт: Тухайн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн хэмжээнд явуулахад баримтлах хууль, эрхзүйн актаар баталгаажуулсан албан ёсны бүтэц, зохион байгуулалт

Байгууллагын үйл ажиллагаа: Тухайн байгууллагын өдөр тутмын болон иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бүхий л үйл ажиллагаа

Хүний нөөцийн бодлогын ил тод байдал: Төрийн байгууллагын албан хаагчийн ажлын зар болон сонгож авах шалгуур үзүүлэлт, түүнтэй холбоотой баримт бичгийг иргэд олж авах боломжоор хангасан байдал

Төсөв, санхүүгийн ил тод байдал: УИХ-аас батлан тухайн төрийн байгууллагад зарцуулах эрх олгосон төсөв, түүний зарцуулалт, төсвийн төсөл, мөн эдгээр баримт бичигт хийгдсэн аудит болон бусад хяналтын тайланг иргэдэд ойлгомжтой байдлаар түгээх, түүнийг ашиглах боломж олгосон байдал

Худалдан авах ажиллагааны ил тод байдал: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдэж буй бүхий л худалдан авалтын урилга болон холбогдох баримт бичгүүдийг ашиглахад хялбар байдлаар иргэдэд түгээх, түүнийг ашиглах боломж олгосон байдал.

9.2 Хавсралт 2. арга зүйн тайлбар

Хүснэгт 26. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт	Хэмжүүр	Хүрээ
Мэдээллийн холбогдолтой байдал (Relevance)	Тухайн цахим хуудас нь ЗГ-ын 143 дугаар тогтоолд заасан мэдээллүүдийг хэрэглэгчдэд өгч байгаа эсэх	Мэдээлэл цогц бүрэн байгаа эсэх	Үйл ажиллагаа
			Хүний нөөц
			Төсөв, санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
Мэдээллийн найдвартай байдал (Reliability)	Тухайн цахим хуудас дахь мэдээлэл хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц байгаа эсэх	Мэдээллийн эх сурвалж тодорхой байгаа эсэх	Хүний нөөц
			Төсөв, санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
Мэдээллийн цаг үеийн байдал (Timeliness)	Цахим хуудас цаг үеийн, ач холбогдлоо алдаагүй мэдээлэл тавьсан эсэх	Тухайн мэдээллийг оруулсан хугацаа тодорхой эсэх	Хүний нөөц
			Төсөв, санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
		Тухайн мэдээлэл хэрэглэгчдэд зориулж боломжит хугацаанд нийтлэгдэж байгаа эсэх	Хүний нөөц
			Төсөв, санхүү байдал
			Худалдан авах ажиллагаа
			Хүний нөөц
Төсөв, санхүү байдал			
Худалдан авах ажиллагаа			
Цахим хуудасны хүртээмжтэй байдал (Accessibility)	Цахим хуудас нь хэрэглэгчид төрийн байгууллагаас шууд хандан мэдээлэл авах боломж олгосон, мөн хоёр талын оролцоог хангасан эсэх	Асуулт хариултын булан байгаа эсэх	Хэлэлцүүлгийн булан байгаа эсэх
			Холбоотой байгууллагын холбоос линк байгаа эсэх
			Тогтмол асуудаг асуултуудын хариулт байгаа эсэх (FAQ)
			Хэлний сонголт байгаа эсэх
Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдал (Usability)	Хэрэглэгчдэд тухайн цахим хуудсын бүтэц, дизайн, үзэмж зэрэг нь ашиглахад хялбар байгаа эсэх	Цахим хуудасны үсгийн хэмжээ тохиромжтой, харагдахуйц байгаа эсэх	Цахим хуудасны цэс ойлгомжтой эсэх
			Цахим хуудас өнгөний зохицолтой эсэх
			Цахим хуудасны бүх мэдээлэл нь нэгэн жигд сонгосон хэл дээр гарч байгаа эсэх
			Цахим хуудасны мэдээлэл уншиж үзэхэд шаардлагатай программыг татаж авах боломжтой байгаа эсэх
			Дурын браузерээс тухайн цахим хуудас руу орох боломж байгаа эсэх
			Цахим хуудаст алдаа гарч байгаа тохиолдолд шийдэх арга замыг зааж өгч байгаа эсэх
			Цахим хуудаст хайлтын цэс байгаа эсэх
			Цахим хуудаст цахим шуудангийн хаяг байгаа эсэх
			Цахим хуудаснаас хэвлэх боломж байгаа эсэх
			Цахим хуудаст файлыг хадгалах боломж байгаа эсэх
			Цахим хуудаснаас мэдээллийг бусдад илгээх боломж байгаа эсэх

Хүснэгт 27. Тухайн шалгуурыг ямар хэмжээнд хангаж байгааг үнэлэх үнэлгээ

Хувь	Холбогдолтой байдал	Найдвартай байдал	Цаг үеийн байдал	Хүртээмжтэй байдал	Хэргэлэхэд хялбар байдал	Ил тод байдал
81-100	Бүрэн холбогдолтой	Мэдээлэл бүрэн найдвартай	Мэдээлэл тогтмол шинэчлэгддэг	Бүрэн хүртээмжтэй	Хэрэглэхэд маш хялбар	Бүрэн ил тод
61-80	Холбогдолтой	Найдвартай	Ихэнхи мэдээлэл шинэчлэгддэг	Хүртээмжтэй	Хэрэглэхэд боломжтой	Ил тод
41-60	Зарим талаар холбогдолтой	Зарим талаар найдвартай	Зарим мэдээлэл шинэчлэгддэг	Зарим талаар хүртээмжтэй	Хэрэглэхэд төвөгтэй	Зарим талаар ил тод
0-40	Мэдээлэл огт байхгүй эсвэл холбогдолгүй	Найдваргүй	Хоцрогдсон мэдээлэл	Хүртээмжгүй	Хэрэглэхэд маш төвөгтэй	Хаалттай

9.3 Хавсралт 3. судалгаанд хамруулсан Цахим хуудсууд

Монгол Улсын яам

1.	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	http://www.mne.mn/
2.	Батлан хамгаалах яам	http://www.mod.gov.mn/
3.	Боловсрол, шинжлэх ухааны яам	http://www.meds.gov.mn/
4.	Гадаад харилцааны яам	http://www.mfa.gov.mn/
5.	Барилга, хот байгуулалтын яам	http://www.mcup.gov.mn/
6.	Сангийн яам	http://www.mof.gov.mn/
7.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	http://www.khun.gov.mn/
8.	Хууль зүйн яам	http://www.moj.gov.mn/
9.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	http://www.mofa.gov.mn/
10.	Эрүүл мэндийн яам	http://www.moh.mn/
11.	Эрчим хүчний яам	http://www.energy.gov.mn/
12.	Зам, тээврийн яам	http://www.mrt.gov.mn/
13.	Хөдөлмөрийн яам	http://www.mol.gov.mn/
14.	Эдийн засгийн хөгжлийн яам	http://www.med.gov.mn/
15.	Уул уурхайн яам	http://www.mm.gov.mn/
16.	Соёл, спорт, аялал жуулчлалын яам	http://www.mcst.gov.mn/

Хэрэгжүүлэгч агентлаг

1.	Ашигт малтмалын газар	http://www.mram.gov.mn/
2.	Архивын ерөнхий газар	http://www.archives.gov.mn/
3.	Газрын тосны газар	http://www.pam.gov.mn/
4.	Гаалийн ерөнхий газар	http://www.customs.mn/
5.	Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	http://www.immigration.gov.mn/
6.	Хөрөнгө оруулалтын газар	http://www.investmongolia.com/
7.	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	http://www.gazar.gov.mn/
8.	Иргэний нисэхийн ерөнхий газар	http://www.mcaa.gov.mn/
9.	Мал эмнэлэг, үржлийн газар	www.dvab.gov.mn
10.	Нийгмийн даатгалын ерөнхий газар	http://ndaatgal.mn/
11.	Оюуны өмчийн газар	http://ipom.mn/
12.	Худалдан авах ажиллагааны газар	http://www.e-tender.mn/

13.	Татварын ерөнхий газар	http://mta.mn/
14.	Улсын бүртгэлийн ерөнхий газар	http://www.citizenmongolia.com/
15.	Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар	http://www.halamj.gov.mn/
16.	Хүүхдийн төлөө үндэсний газар	http://www.nac.gov.mn/
17.	Цаг уур, орчны шинжилгээний газар	http://www.namhem.pmis.gov.mn/
18.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	http://www.court-decision.gov.mn/
19.	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	http://cabinet.gov.mn/

Тохируулагч агентлаг

1.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	http://www.ssia.gov.mn/
2.	Онцгой байдлын ерөнхий газар	http://www.desasterinfo.mn/
3.	Стандартчилал, хэмжил зүйн газар	http://www.masm.gov.mn/
4.	Төрийн өмчийн хороо	http://www.spc.gov.mn/
5.	Тагнуулын ерөнхий газар	http://www.gia.gov.mn/
6.	Хил хамгаалах ерөнхий газар	http://www.bpo.gov.mn/
7.	Цагдаагийн ерөнхий газар	http://www.police.gov.mn/
8.	Цөмийн энергийн газар	http://www.nea.gov.mn/
9.	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	http://www.ursulduun.mn/
10.	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	http://www.itpta.gov.mn/
11.	Зэвсэгт хүчний жанжин штаб	http://www.govgsmaf.pmis.gov.mn/

Орон нутгийн ЗДТГ

1.	Архангай	http://www.arkhangai.gov.mn
2.	Баян-Өлгий	http://www.bayanulgii.gov.mn
3.	Баянхонгор	http://www.bayankhongor.mn
4.	Булган	http://www.bulgan.gov.mn
5.	Говь-Алтай	http://www.govi-altai.gov.mn
6.	Говьсүмбэр	http://www.govisumber.gov.mn
7.	Дархан-Уул	http://www.e-darkhan.com
8.	Дорноговь	http://www.dornogobi.gov.mn
9.	Дорнод	http://www.dornod.gov.mn
10.	Дундговь	http://www.dundgovi.gov.mn
11.	Завхан	http://www.zavkhan.mn
12.	Орхон	http://www.erdenet.mn
13.	Өвөрхангай	http://www.uvurkhangai.gov.mn
14.	Өмнөговь	http://www.umnugovi.gov.mn
15.	Сүхбаатар	http://www.sukhbaatar.mn
16.	Сэлэнгэ	http://www.selenge.mn
17.	Төв	http://www.tuv.mn
18.	Увс	http://www.uvsmongolia.mn
19.	Хөвсгөл	http://www.huvsgul.mn
20.	Хэнтий	http://khentii.mn/
21.	Ховд	http://www.khovd.gov.mn/

Парламентийн харьяа байгууллагууд

1.	Төрийн албаны зөвлөл	http://csc.gov.mn
2.	Авлигатай тэмцэх газар	http://www.iaac.mn/
3.	Санхүүгийн зохицуулах хороо	http://www.frc.mn/
4.	Сонгуулийн ерөнхий хороо	www.gec.gov.mn
5.	Хүний эрхийн үндэсний комисс	www.mn-nhrc.org
6.	Үндэсний аудитын газар	www.mnao.mn
7.	Үндэсний статистикийн хороо	www.nso.mn/

8.	Монголбанк	www.mongolbank.mn
9.	Монгол Улсын Их Хурал	www.parliament.mn

Улаанбаатарын дүүргүүдийн ЗДТГ

1.	Нийслэл Улаанбаатар хот	http://www.ulaanbaatar.mn
2.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	http://www.ubservice.mn
3.	Баянгол дүүрэг	http://www.bgd.mn
4.	Багахангай дүүрэг	http://www.bagakhangai.ub.gov.mn
5.	Баянзүрх дүүрэг	http://www.bzd.ub.gov.mn/
6.	Багануур дүүрэг	www.bnd.ub.gov.mn
7.	Чингэлтэй дүүрэг	www.chingeltei.gov.mn
8.	Сүхбаатар дүүрэг	www.sbd.ub.gov.mn
9.	Сонгинохайрхан дүүрэг	www.shd.mn/
10.	Хан-Уул дүүрэг	www.khanuul.mn
11.	Налайх дүүрэг	www.nad.ub.gov.mn

9.4 Хавсралт 4. Цахим хуудсуудын эрэмбэлэлт

Байр	Төрийн байгууллагууд	Мэдээллийн хамааралтай байдал	Мэдэллийн найдвартай байдал	Мэдээллийн цаг үеийн байдал	Мэдээллийн хүртээмжтэй байдал	Цахим хуудас хэрэглэхэд хялбар байдал	Нийлбэр хувь
1	Говь-Алтай аймгийн ЗДТГ	20,4	15,4	17,1	3	15,0	70,8
2	Татварын ерөнхий газар	16,1	9,2	8,8	12	12,5	58,6
3	Орхон аймгийн ЗДТГ	19,3	4,6	12,4	9	11,3	56,5
4	Дорноговь аймгийн ЗДТГ	17,1	7,7	15,3	3	12,5	55,6
5	Хөвсгөл аймгийн ЗДТГ	15,0	10,8	14,7	3	11,3	54,7
6	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	18,2	0,0	14,7	9	12,5	54,4
7	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	18,2	10,8	11,8	3	10,0	53,7
8	Дорнод аймгийн ЗДТГ	17,1	6,2	10,0	9	11,3	53,5
9	Төрийн өмчийн хороо	16,1	10,8	10,6	9	6,3	52,7
10	Улсын бүртгэлийн ерөнхий газар	17,1	9,2	7,1	6	10,0	49,4
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	17,1	10,8	10,0	3	7,5	48,4
12	Монгол улсын хөдөлмөрийн яам	20,4	0,0	10,6	6	11,3	48,2
13	Хүний эрхийн үндэсний комисс	16,1	0,0	14,7	6	11,3	48,0
14	Цаг уур, орчны шинжилгээний газар	15,0	9,2	7,6	6	10,0	47,9
15	Ашигт малтмалын газар	17,1	7,7	7,6	6	8,8	47,2
16	Сонгуулийн ерөнхий хороо	13,9	0,0	9,4	9	13,8	46,1
16	Зам тээврийн яам	18,2	0,0	10,6	6	11,3	46,1
17	Эрчим хүчний яам	18,2	1,5	4,7	6	15,0	45,5
18	Үндэсний статистикийн хороо	15,0	0,0	10,0	9	11,3	45,3
19	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газар	15,0	4,6	4,7	12	8,8	45,1
20	Худалдан авах ажиллагааны газар	12,9	9,2	7,6	9	5,0	43,7
21	Гаалийн ерөнхий газар	16,1	6,2	4,7	9	7,5	43,4
21	Баянгол дүүргийн ЗДТГ	13,9	1,5	7,6	9	11,3	43,4
22	Боловсрол, шинжлэх ухааны яам	11,8	4,6	5,9	6	15,0	43,3
23	Дархан-Уул аймгийн ЗДТГ	9,6	9,2	8,8	3	11,3	41,9
23	Баянхонгор аймгийн ЗДТГ	15,0	9,2	4,7	3	10,0	41,9
24	Дундговь аймгийн ЗДТГ	16,1	0,0	7,1	6	12,5	41,6

25	Цагдаагийн ерөнхий газар	10,7	7,7	7,6	9	6,3	41,3
26	Увс аймгийн ЗДТГ	11,8	6,2	5,9	6	11,3	41,1
27	Нийслэлийн ЗДТГ	12,9	1,5	11,8	6	8,8	40,9
28	Уул, уурхайн яам	18,2	0,0	8,2	3	11,3	40,7
28	Өмнөговь аймгийн ЗДТГ	18,2	0,0	8,2	3	11,3	40,7
29	Үндэсний аудитын газар	11,8	1,5	9,4	6	11,3	40,0
30	Чингэлтэй дүүргийн ЗДТГ	12,9	3,1	9,4	3	11,3	39,6
31	Сангийн яам	16,1	0,0	5,9	6	11,3	39,2
31	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	10,7	3,1	7,6	9	8,8	39,2
32	Архивын ерөнхий газар	15,0	4,6	5,9	6	7,5	39,0
32	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	12,9	0,0	5,9	9	11,3	39,0
33	Эдийн засгийн хөгжлийн яам	12,9	0,0	11,8	3	11,3	38,9
34	Барилга, хот байгуулалтын яам	17,1	0,0	4,1	6	11,3	38,5
35	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	12,9	4,6	4,1	6	10,0	37,6
35	Монгол банк	11,8	0,0	1,8	9	15,0	37,6
36	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	12,9	6,2	5,3	3	10,0	37,3
37	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	13,9	0,0	5,9	6	11,3	37,1
38	Төрийн албаны зөвлөл	13,9	0,0	2,4	9	11,3	36,5
39	Ховд аймгийн ЗДТГ	10,7	1,5	9,4	3	11,3	35,9
39	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	13,9	0,0	4,7	6	11,3	35,9
40	Санхүүгийн зохицуулах хороо	10,7	0,0	4,7	6	13,8	35,2
41	Хил хамгаалах ерөнхий газар	9,6	3,1	2,4	12	7,5	34,6
42	Хэнтий аймгийн ЗДТГ	10,7	6,2	5,9	3	8,8	34,5
43	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	13,9	0,0	5,3	6	8,8	34,0
44	Стандартчилал, хэмжил зүйн газар	13,9	6,2	4,7	0	8,8	33,5
45	Батлан хамгаалахын яам	8,6	3,1	4,7	3	13,8	33,1
46	Авлигатай тэмцэх газар	13,9	0,0	4,7	3	11,3	32,9
46	Завхан аймгийн ЗДТГ	9,6	3,1	5,9	3	11,3	32,9
47	Иргэний нисэхийн ерөнхий газар	7,5	4,6	2,9	9	8,8	32,8
48	Монгол Улсын Их хурал	6,4	0,0	2,9	12	11,3	32,6
49	Төв аймгийн ЗДТГ	5,4	1,5	8,2	6	11,3	32,4
50	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	10,7	0,0	4,1	6	11,3	32,1
51	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	12,9	4,6	5,3	3	6,3	32,0
52	Булган аймгийн ЗДТГ	6,4	3,1	1,8	9	11,3	31,5
53	Соёл урлаг, аялал жуулчлалын яам	9,6	0,0	0,0	9	12,5	31,1

53	Налайх дүүргийн ЗДТГ	10,7	7,7	7,6	0	5,0	31,1
54	Нийгмийн даатгалын ерөнхий газар	11,8	1,5	4,1	6	7,5	30,9
55	Цөмийн энергийн газар	11,8	6,2	5,3	0	7,5	30,7
56	Баянзүрх дүүргийн ЗДТГ	9,6	0,0	0,6	9	11,3	30,5
57	Мал эмнэлэг, үржлийн газар	11,8	4,6	3,5	3	7,5	30,4
58	Хүүхдийн төлөө үндэсний газар	7,5	6,2	4,1	6	6,3	30,0
59	Онцгой байдлын ерөнхий газар	10,7	1,5	1,2	6	10,0	29,4
60	Гадаад харилцааны яам	11,8	0,0	1,8	3	11,3	27,8
61	Тагнуулын ерөнхий газар	8,6	0,0	0,0	9	8,8	26,3
62	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	6,4	3,1	2,4	3	11,3	26,1
63	Хууль зүйн яам	8,6	0,0	0,0	6	11,3	25,8
64	Багануур дүүргийн ЗДТГ	9,6	1,5	1,2	3	10,0	25,4
65	Эрүүл мэндийн яам	9,6	0,0	3,5	0	11,3	24,4
66	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	9,6	0,0	2,9	3	7,5	23,1
67	Улаанбаатар хотын захирагчийн алба	9,6	0,0	0,0	3	10,0	22,6
68	Архангай аймгийн ЗДТГ	2,1	0,0	0,0	9	11,3	22,4
69	Сүхбаатар аймгийн ЗДТГ	6,4	0,0	5,3	3	7,5	22,2
70	Багахангай дүүргийн ЗДТГ	9,6	1,5	4,7	0	6,3	22,1
70	Өвөрхангай аймгийн ЗДТГ	8,6	0,0	3,5	0	10,0	22,1
71	Оюуны өмчийн газар	9,6	1,5	1,2	3	5,0	20,4
72	Хан-Уул дүүргийн ЗДТГ	5,4	0,0	0,0	6	8,8	20,1
73	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	6,4	0,0	0,0	6	5,0	17,4
74	Хөрөнгө оруулалтын газар	7,5	0,0	0,0	3	6,3	16,8
75	Газрын тосны газар	6,4	0,0	0,6	3	6,3	16,3
76	Зэвсэгт хүчний жанжин штаб	5,4	0,0	0,0	3	6,3	14,6

